

Олон нийтэд зориулав.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

/2018.10.01-2019.02.02/

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

АГУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганыг нээж УИХ-ын дарга М.Энхболдын хэлсэн үг	7
-------------------------------------------------------------------------------------------------------	---

НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны нэгдсэн тойм.....	22
----------------------------------------------------------------------------------------	----

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД, ТҮР ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Улсын Их Хурлын Байнгын болон Дэд, Түр хороодын бүрэлдэхүүн	26
2.2. Байнгын хороодын үйл ажиллагааны талаарх мэдээлэл	27

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар	62
3.2. Улсын Их Хурлын гишүүдийн тавьсан асуулга, асуулт.....	64
3.3. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл	65

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Мэдээлэл, сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа	76
4.2. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	78
4.3. Мэдээллийн технологи, техник ашиглалтын мэдээ.....	79
4.4. Судалгаа шинжилгээ, мэдээлэл, лавлагаа	81
4.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.....	82

ТАВ. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын жагсаалт	90
Хавсралт 2. Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	96

А) Төрийн байгуулалтын болон хууль зүйн чиглэлээр

1. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга.....	96
2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	97
3. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	98
4. Сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн танилцуулга.....	99
5. М.Энхболдыг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	99
6. Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол, Г.Занданиатарыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	100
7. Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	100
8. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	101
9. Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	102
10. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	102
11. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	103
12. Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	104
13. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай, Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга	105

14. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолуудын танилцуулга.....	105
15. Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	105

Б) Төсөв, санхүүгийн чиглэлээр

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн танилцуулга.....	107
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	111
3. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуультай хамт батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	112
4. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	115

В) Эдийн засгийн чиглэлээр

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	116
-----------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----

Г) Нийгэм, боловсрол, соёл, шинэжлэх ухааны чиглэлээр

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн танилцуулга.....	117
2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн танилцуулга.....	118
3. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга.....	119

Д) Байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр

1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга..... 120

Е) Аюулгүй байдал, олон улсын гэрээ, конвенцийн чиглэлээр

1. “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төслийн зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 121
2. Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1907 оны конвенцыг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 122
3. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 123
4. “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 124
5. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 125
6. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ” соёрхон батлах тухай танилцуулга..... 126
7. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь - II төсөл”-ийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 127
8. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 128
9. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн танилцуулга..... 129

10. “Мянганы сорилтын компакт гэрээ” соёрхон батлах тухай хуулийн танилцуулга.....	130
11. “Иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ” соёрхон батлах тухай хуулийн танилцуулга.....	131
12. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ” соёрхон батлах тухай хуулийн танилцуулга.....	132
13. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ” соёрхон батлах тухай хуулийн танилцуулга.....	133
14. Монгол Улсын ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын танилцуулга.....	134
Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганыг хааж УИХ-ын дарга Г.Занданшатарын хэлсэн үг	135
Товчилсон үгийн жагсаалт	139

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ НЭЭЖ УИХ-ЫН ДАРГА М.ЭНХБОЛДЫН ХЭЛСЭН ҮГ



*Монгол Улсын Ерөнхийлөгч өө,
Хүндэт Ерөнхий сайд аа,
Улсын Их Хурлын эрхэм гишүүд,
Хүндэт зочид оо,*

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаа эхлүүлэхээр Та бид хуран цуглаад байна.

Монгол Улсын Их Хурлын болон дэгийн тухай хуульд нэмж оруулсан гишүүдийн сахилга, хариуцлагатай холбоотой заалтуудын хүрээнд үйл ажиллагаа явуулахаараа энэ удаагийн чуулган онцлог юм. Хариуцлагыг эрхэмлэж, ёс зүйгээ дээдлэн, сонгогч түмнийхээ итгэлийг дааж, өргөсөн тангаргаа сахин биелүүлэхэд бидэнд хуулийн өөрчлөлт чухал түлхэц үзүүлнэ гэдэгт найдаж байна.

Энэ намрын чуулган бодлого, үйл ажиллагаагаа дараах үндсэн 5 чиглэлд төвлөрүүлэх ёстой гэж үзэж байна.

Нэгдүгээрт, Монгол төрийн чадавхыг сайжруулах чиглэлд хууль тогтоох байгууллагын анхаарал төвлөрөх шаардлагатай болжээ.

Төрийн чадавхыг сайжруулах талаар олон жил ярилаа. Гэвч үр дүн бага байгааг нуух хэрэггүй. Тиймээс эрх зүйн зоримог шинэчлэл хийх, түүнийгээ тууштай, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага Монголын нийгмийн захиалга болоод байна. Энд юуны өмнө Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнийг батлах асуудал юм.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх, шаардлагатай бол ямар чиглэлээр оруулах вэ гэдгийг хоёр жилийн хугацаанд судалж, эрдэмтэн мэргэд, ард иргэдтэйгээ зөвшилцлөө. Орон даяар хэлэлцүүлэг явуулж, иргэдийнхээ саналыг авснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл бэлэн болсон. Одоо хуулийн дагуу холбогдох байгууллагуудаас санал авч байна.

Өнөөгийн нийгэм, улс төрийн тогтолцоонд тохиож буй саад бэрхшээл, хөгжлийн бодлого, хариуцлагатай, шударга засаглалыг төлөвшүүлэх зорилтыг хангахын тулд Үндсэн хуульд өөрчлөлт хийх нь зөв гэдэгт иргэдийн дийлэнх олонх нь санал нэгдэж байгаа. Зайлшгүй шаардлагатайг хийхгүйгээр хэзээ, хэн хийнэ гэж хүлээж суух вэ. Хойш тавих тусам хожигдох эрсдэл ихэснэ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах ажлын хэсэгт улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид орсон. Энэ бол нэг намынх биш, хэд хэдэн парламент дамжин яригдаж, судлан шинжилж, ард түмнийхээ санал бодлыг шингээн, нийтээрээ хамтарч боловсруулсан төсөл юм. Тиймээс хэлэлцэхийг эрмэлзэх нь зүйтэй.

Улс төрийн намын ил тод байдал, санхүүжилтийн эрх зүйн орчныг өөрчлөх асуудал намрын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад байгаа. Намуудын үйл ажиллагаа ил тод, бодлого хөтөлбөр нь тодорхой, ялангуяа санхүүжилтийн тогтолцоо шилэн байх нь улс төр эрүүл байхын үндсэн нөхцөл юм.

Бүх шатны сонгууль явцуу зорилго, мөнгөний хамааралтай болж, зөв бодлого, итгэл даах үнэ цэнэ, мэдлэг туршлагын үнэлэмж алдагдаж байгааг Та бид бүгдээрээ л харж байна. Үүнд хэн нэгнийг буюу аль нэг улс төрийн хүчнийг буруутгаж, яллахыг оролдсоноор асуудал шийдэгдэхгүй нь ойлгомжтой юм. Харин эрх зүйн дорвитой өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх нь чухал байна.

Сонгуулийн хууль тогтоомжийн шинэчлэл ч үүнд хамаарна. Улсын Их Хурлын эрхэм гишүүд маань өөрөө сонгогдох, намаа ялуулах боломжийг хайх биш, Монголынхоо эрх ашгийн төлөөх сонголтыг чухалчилна гэдэгт итгэж байна.

Их Британид байрладаг Эдийн засгийн мэдээллийн байгууллагаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн 165 оронд хийсэн Ардчиллын индексийн судалгаагаар сул буюу муухан ардчилалтай улсын ангилалд манай улс орсон байна. Энэ ангилалд сонгууль нь ардчилсан зарчмаар, чөлөөтэй явагддаг боловч улс төрийн соёл муутай, иргэдийн улс төрийн идэвх сул улсууд багтдаг юм байна.

Монголчуудын улс төрийн соёл муу гэдэгтэй санал нийлэх хүн олдох байх. Харин улс төрд оролцох оролцоо муу гэдэгтэй санал нийлэмгүй байна. Улс төр ярьдаггүй, улстөрждөггүй хүнийг олох бас тийм амар биш ээ. Гагцхүү улс төрийн яриа хөөрөө нь популизмын хэвлийд голдуу бүрэлдэж, тархи угаах тааруу инкубаторт торниж байдаг нь бидний үйл ажиллагаанд ихээхэн гай тарьж байна. Улс төрийн популизм манайд хэт газар авч, сүүлдээ байх л ёстой зүйл шиг ойлгодог, хүлээж авдаг болжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа нийгмийн сүлжээгээр бусдыг гутаах арга технологи бидний амьдралд ердийн үзэгдэл болтлоо хэвшлээ. Үүнийг зохион байгуулж, санхүүжүүлэгч улс төрчид үндэстнээ хорлох, улсаа гутаах энэ арга барилаасаа нэн даруй салах хэрэгтэй юм.

Эрдэмтэн судлаачид өндөр хөгжилтэй улс орны улс төрийн бодлогод популизм биш, прагматизм голлох үүрэгтэй байгааг сануулсаар байна. Төрийн бодлого тодорхойлохдоо элдэв хийсвэр томъёолол тойрон маргаж, ухаантнаар өөрийгөө тодруулахыг зорилгоо болгох ёсгүй. Эдийн засгийн боломж, төрийн бодлого, хэтийн зорилтдоо үндэслэж, зөв замаар итгэлтэй урагшлах прагматик бодлого бидэнд үгүйлэгдсээр байна.

Хоосон улстөржилт, талцал хуваагдал, нийгэм, ард түмнээ хуваасан дайсангал бидэнд огт хэрэггүй. Харин зөвшилцөл, ойлголцол хэрэгтэй байна. Тиймээс Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийнхэн, ард иргэд хамтраад тулгамдсан асуудлаар үндэсний зөвшилцөл хийдэг, гаргасан шийдвэрээ биелүүлдэг тогтолцоонд шилжихийг уриалж байна. Энэ зорилгоор “Үндэсний зөвшилцлийн гэрээ” санаачлан хэрэгжүүлсэн ч болохгүй зүйл үгүй.

Эрхэм нөхөд өө,

Чуулганы нээлтэд шүүх эрх мэдлийн байгууллагууд, яам, агентлаг, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын удирдлага оролцож байна.

Төр бол томоохон ажил олгогч. Ажил олгогчийнхоо хувиар Та бүгдээр дамжуулан 192 мянга гаруй ажилтнаа захиргааны удирдлагаар хангадаг. Тиймээс төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, төрийн албаны нэр хүнд Та бүхнээс шууд хамааралтай юм.

Төрийн байгууллагын дотоод хяналт суларч, удирдлага, зохион байгуулалт алдагдсаны уршгаар төрийн албан хаагч нэгнийхээ аминд хүрсэн ноцтой хэрэг гарлаа. Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан хуулийг ягштал баримталж, сахилга хариуцлага, ёс зүйг эрхэмлэхийг хатуу шаардаж, зөрчил гаргасан этгээдтэй хариуцлага тооцож ажиллах ёстой.

Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан “Төрийн албаны тухай хууль” ирэх оноос хэрэгжиж эхэлнэ. Төрийн албыг улс төрийн нөлөөнөөс хол байлгах, төрийн албанд шатлан дэвших мерит зарчмыг хэвшүүлэх замаар төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх зорилготой шинэ хуулийг мөрдөж, саяхан болсон улсын зөвлөгөөнөөс гаргасан Зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Та бүхэн манлайлж ажиллах ёстойг сануулъя.

Хоёрдугаарт, бизнесийн орчныг сайжруулахгүйгээр эдийн засгаа өсгөж, ард түмний амьжиргааг дээшлүүлэх талаар ярих боломжгүй юм.

Өр, өрийн хүүд дарлуулж, эдийн засгийн уналт зогсолтгүй үргэлжилсэн, улс орон хямралын ирмэгт ирсэн хүнд хэцүү үеийг бид даван туулж чадлаа.

Эдийн засгийн бодит өсөлт 2018 оны эхний хагасын байдлаар 6.3 хувьд хүрч, 2016 онтой харьцуулахад 5.1 пунктээр өссөн байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого энэ оны эхний 8 сарын байдлаар 5.8 их наяд төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 888.0 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Монгол Улсын Засгийн газар 2018 онд гадаад, дотоодын зээлийн өр, өрийн хүүд 3.8 их наяд төгрөг төлөх ёстойгоос эхний хагас жилд 753.3 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан. Өнөөгийн үнэ цэнээр тооцсон Засгийн газрын өр 2016 онд ДНБ-ий 78.8 хувьд хүрч байсан бол 2018 оны эхний хагас жилийн байдлаар 63.4 хувь болж буурсан байна.

Зээлийн үйлчилгээний төлбөр 2018 оны эхний 8 сарын байдлаар төлөвлөсөн дүнгээс 132.2 тэрбум төгрөгөөр буюу 17.1 хувиар бага байгаа нь энэ онд хүүгийн зардал буурах төлөвийг харуулж байгаа юм. Энэ мэт нааштай өөрчлөлт гарахад дэлхийн зах зээл дээрх экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс гадна сүүлийн 2 жилд явуулсан төсөв, санхүү, мөнгө, зээлийн зөв бодлого шийдвэрлэх нөлөө үзүүлээ.

Энэ чуулган ирэх оны мөнгөний бодлого, улсын төсвөө хэлэлцэн батална. Ингэхдээ бодлогоо тогтвортой хадгалж, өсөлтийг иргэддээ хүртээх чиглэлд түлхүү анхаарах шаардлагатай байна.

2018 оны 1 дүгээр сараас тэтгэвэр, тэтгэмжийг 8 хувиар, 9 дүгээр сарын эхнээс төрийн зарим албан хаагчдын цалинг 8-30 хувиар нэмэх шийдвэр гарсан. Ирэх онд ч төсөв санхүүгийн боломжтойгоо уялдуулан цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх хөрөнгийг улсын төсөвт суулгах ёстой.

Төрийн алба цомхон, чадварлаг байх учиртай. Хоёр жилийн өмнө төсөв зардлаа хэмнэх шийдвэрийг Улсын Их Хурал гаргаж байсан. Энэ дагуу Улсын Их Хурлын Тамгын газар орон тоо зардлаа 10 хувь бууруулснаар урсгал зардлыг 546.4 сая төгрөгөөр хэмнэжээ. Харин төрийн бусад байгууллага орон тоо зардлаа бууруулах дорвитой арга хэмжээг авсангүй. Энэ жилийн төсвийг хэлэлцэхдээ төрийн бүх шатны байгууллагад орон тоо зардлыг 10 хувиар бууруулах бодлого баримтлахыг уриалж байна.

Төсвийг батлахдаа дэлхийн эдийн засгийн төлөв, хандлагыг сайтар тооцох шаардлагатай байгааг зориуд би энд сануулъя. Олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааны эрсдэл төсөөлснөөс хурдацтай нэмэгдэж байна. Том гүрнүүдийн гадаад худалдааны харилцан хязгаарлалт, нефтийн бүтээгдэхүүний хориг, бодлогын хүүгийн өсөлт, голлох валютын ханшийн сулралт ирэх онд үргэлжилнэ гэж шинжээчид үзэж байна.

Энэ нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг хязгаарлан, гадаад зах зээлийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, хөгжиж буй орнууд, ялангуяа эмзэг эдийн засгийн бүтэцтэй улс орнуудад нэлээд дарамт учруулах магадлалтай юм.

Манайд энэ дарамт мэдрэгдэж эхлээд байна. Эдийн засаг, бизнесийн орчин сайжирч байгаа ч гадаад өөрчлөлтийн эрсдэлийг даах чадвар сул, дунд хугацааны төлөв нь эрсдэлтэй, эмзэг хэвээр байгаа. Энэ нь гадаад зах зээлийн багахан өөрчлөлт, дотоодын импортын сэргэлтийг дийлэхгүй, сүүлийн нэг сарын дотор төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2.2 хувиар суларснаас харагдаж байна. Тиймээс төсөв, мөнгөний бодлогыг хэлэлцэхдээ дараах асуудалд анхааръя.

А. Гадаад эрсдэлийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, тогтвортой өсөлтийг хангах бодлого чухал. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодитой арга хэмжээ авах, валютын нөөцийг нэмэгдүүлэх, экспортын дэд бүтцийн хүндрэлийг арилгах, банк, санхүүгийн салбарын шинэчлэл, төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг тууштай үргэлжлүүлэх ёстой.

Б. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатай. Гадаад зах зээлийн өөрчлөлтөд нэрвүүлчихгүй дархлаатай, өөрийгөө тэтгэх чадвартай, экспортод чиглэсэн эдийн засгийн бүтэц рүү шилжихгүй бол Өсөлт ба Уналт, Орлого ба Хэрэглээ, Тогтворгүй байдал ба Ядуурал гэсэн гинжин хэлхээнээс салахгүй.

В. Хөрш орнуудтай харилцах эдийн засгийн дипломат үйл ажиллагааг шинэ шатанд гаргах хэрэгтэй байна. Хувийн хэвшлийнхэн экспортын зах зээлд худалдааны таатай нөхцөлөөр нэвтрэх, хамтарсан бизнес эрхлэх боломжуудыг шинээр нээхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд хэрэгтэй болжээ. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны гишүүн 48 орон тус бүр дунджаар 11 чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан байхад бид ганц хэлэлцээрийг 3 жилийн өмнө л байгуулсан байх жишээтэй. Цаашид хөрш болон бусад орнуудын хэрэгжүүлж буй бүс нутгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийн өгөөжөөс бид гээгдэж хоцрох ёсгүй.

Эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Улсын Их Хурал онцгой ач холбогдол өгч байна. Түүнчлэн “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийг хэлэлцэн батлахыг олон нийт хүсэн хүлээж байгааг мартаж болохгүй.

Эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон түлхэц үзүүлэх уул уурхай, эрчим хүч, төмөр зам, авто зам, боловсруулах үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн салбарын төсөл, хөтөлбөрүүдийг цэц булаалдсан яриа маргаанаас бодит ажил хэрэг рүү хандуулах нь чухал байна.

Энэ дашрамд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан, “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компаниас гаргасан зээлийн баталгааны талаар, мөн Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэгтэй Ажлын хэсэг дүгнэлтээ Байнгын хороо болон Улсын Их Хуралд ойрын үед танилцуулахыг даалгая.

Мөн Улсын Их Хурлаас Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар тогтоол баталсан. Хэрэгжилтийг 2018 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг үүрэг болгосныг сануулъя.

2018 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 683.3 тэрбум төгрөг төлөвлөснөөс 176.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, 25.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Сургууль, цэцэрлэг, зам гүүрийн ажил тогтсон хугацаандаа багтаж эхэлдэггүй уламжлал энэ жил ч давтагдаж байгаад анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байна.

Гурав. Боловсрол бол манай тэргүүлэх салбар. Түүнээс дутахгүй ач холбогдолтой нь эрүүл мэндийн салбар юм.

Чанартай боловсрол эзэмшсэн, эрүүл монгол хүн л Монголын ирээдүйг бүтэн, зөв авч явж чадна.

Бага, дунд боловсролын хүртээмж, өгөөжийг сайжруулахгүйгээр, дээд боловсролын байгууллагуудад тооноос чанарт шилжих хувьсал хийхгүйгээр энэ эрхэм зорилтыг бид хэрэгжүүлж чадахгүй нь.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын чанарын асуудалд түлхүүр хүчин зүйл нь багш, эмч нарын чадавх юм. Улсын Их Хурал өнгөрсөн чуулганаараа “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль баталсан. Төсөв мөнгө байхгүй гэх мэт шалтгаан тоочилгүйгээр хуулиа хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй байна.

Энэ намар багш нарын ажил хаялт нийгэмд сүрхий давлагаа үүсгэлээ. Багш, эмч гээд төрийн байгууллагын ажилтнуудын цалин бага байгаа нь үнэн юм. Нэмэх ч ёстой. Гэхдээ боломж нөөцөө тооцох, нөхцөл байдлаа нүүр нүүрээ харж сууж байгаад ойлголцох нь илүү зөв алхам билээ. Төр засгийн байгууллага, удирдлагууд иргэдийнхээ дунд орж, санал бодлыг нь сонсох, ярилцах, хамтын шийдвэр гаргах нь илүү өгөөжтэй юм. Ингэж чаддаггүйгээс ажил хаялт, жагсаал цуглаандаа хүрч, эцэст нь арга буюу буулт хийх замаар асуудлыг шийддэг жишгийг халах цаг болсон.

Засгийн газар 2006 оноос эхлэн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс өргөн мэдүүлсэн “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хуулийн төсөлд “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон өргөжүүлэхээр тусгасан. Түүнчлэн хүүхдийг эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангах арга хэмжээг шим тэжээлийн мэдлэг олгох, зохистой хооллох дадал төлөвшүүлэх сургалт, мэдээлэлтэй нягт уялдуулан цогцоор нь шийдвэрлэх агуулга энэ хуульд туссан.

Эрүүл мэндийн салбарт амжилт олж байна. Эрхтэн шилжүүлэн суулгах ажил дэлхийн жишигт дөхөж очлоо. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр үр дүнд хүрч байна. Олон улсын жишгийн эмнэлгүүд байгуулагдлаа.

Гэсэн хэрнээ ДОХ-ыг бид тоохоо болилоо. Бэлгийн замын халдварт өвчин газар авч байгааг халагласаар л сууна. Зүрх, судасны эрхтэн тогтолцооны өвчлөл нэмэгдэж, залуужиж байна. Тиймээс “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийг сэргээж, жилд нэг удаа бүх монгол хүнийг эрүүл мэндийн үзлэгт оруулдаг болмоор байна. Бүх шатны ажил олгогчид ажилтнаа үзлэг оношилгоонд хамруулдаг, зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг болъё.

2016 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлт хангалтгүй байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх журам, түүнчлэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт одоо болтол гараагүй байна. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журмаа бас баталсангүй. Журам нь шинэчлэгдээгүй болохоор 12 эмнэлгийн дарга, захирлыг сонгон шалгаруулалтгүй томилсон зөрчил бас гарсан байна.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг дүгнэн цэгнэх хэрэгтэй.

Хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах эрх зүйн тогтолцоо хангалттай бүрдсэн. Агентлаг, яамд салбарынхаа хүрээнд хуулийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангадаг. Засгийн газар Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах шаталсан тогтолцоотой.

Та бид чамгүй олон хууль, тогтоол батлан гаргасан. Ажлын тоон үзүүлэлтээр өмнөх парламентуудаас хамаагүй илүү байгаа. Харин хууль хэрэгжүүлэх ажил ямар байна вэ. Би ганцхан хуулийн хэрэгжилтийн талаар авсан мэдээг танилцуулъя.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж байна. Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр Мал эмнэлгийн ерөнхий газрыг байгуулсан. Хуулиар сум, дүүрэгт мал эмнэлгийн байгууллага, лаборатори, нэгж байгуулж, ажиллуулах ёстой. Гэтэл 15 аймагт л мал эмнэлгийн байгууллагын даргыг томилжээ. Аймаг, сумын хэмжээнд нэг ч нэгж шинэчлэн зохион байгуулагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, агентлаг байгуулж, хэдэн дарга томилсноос өөрөөр хуулийн биелэлтийг зохион байгуулах талаар авсан арга хэмжээ алга. Улмаар мал эмнэлгийн үйлчилгээг иргэддээ хүргэх тогтолцоо бүрдсэнгүй. Малаа эрүүлжүүлэх, мах экспортлох, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн уламжлалт салбараа дэмжих бодлого тэр хэрээр хоцорч байна.

Тиймээс хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах ажилдаа дүн шинжилгээ хийхийг Засгийн газарт даалгая.

Хүүхэд хамгаалал, хүүхдийн аюулгүй байдал манайд хангагдаж чадахгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийн тоо өсөж, хүүхэд харамсалтайгаар амь эрсдэх тохиолдол гарсаар байна. Хууль зүйн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хамтарсан Ажлын хэсэг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай зэрэг хуулиудын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, холбогдох үүрэг, чиглэлийг Засгийн газарт өгсөн. Энэ чуулганы хугацаанд өгсөн чиглэл, гаргасан тогтоолынхоо биелэлтэд хяналт тавьж, нэгтгэн дүгнэх нь зүйтэй.

Хүүхэд хамгаалал, цахим аюулгүй байдлын чиглэлээр Цахим бодлогын түр хороо тодорхой ажлууд санаачилж байгаа. Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, Зөвлөмж гаргаснаа надад ирүүлсэн. Зөвлөмжид мэдээллийн аюулгүй байдал, цахим орчин, хүүхдийн хүмүүжил, залуучуудын мэдээлэл солилцох гээд зайлшгүй анхаарвал зохих цөөнгүй асуудал байгааг холбогдох байгууллагууд анхаарч, хамтарч ажилламаар байна.

Намрын чуулганаар хэлэлцэх Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бага насны хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэгчдэд оноох ялын бодлогыг чангатгах талаар эхчүүдээс гаргасан саналыг тусгах хэрэгтэй юм.

Хүүхэд, залуучуудыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оногдуулах ял, шийтгэлийн бодлогыг оновчтой тогтооход анхаарч ажиллахыг гишүүдээсээ хүсье.

Тав. Тулгамдсан, анхаарал татсан зарим асуудлаар би байр сууриа товч илэрхийлье.

Энэ жил агаар, орчны бохирдлыг бууруулах ажилд ямар дорвитой өөрчлөлт гарах вэ гэж асуумаар байна.

Зарцуулсан хөрөнгө үр ашигтай байж чадсан уу. Улсын Их Хурал, Засгийн газар, нийслэлийн түвшинд тодорхой ажлууд зохион байгуулсан. Одоо үр дүн хэрэгтэй байна. Нэг өвөл гэнэтхэн утаагүй болчихгүй гэдгийг ойлгож байна. Гэхдээ авсан арга хэмжээ гарцаагүй зөв, ужиг энэ асуудлаа бүрэн шийдвэрлэж чадах нь ээ гэсэн итгэл төрүүлж байх нь чухал юм.

Утаанаас дутуугүй иргэдийг бухимдуулж буй асуудал нь авто замын түгжрэл юм. Тиймээс импортын автомашины татварыг насжилттай нь уялдуулах, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гүүр болон давхар замын байгууламж барих зэрэг зөв шийдэлтэй арга хэмжээг хугацаа алдалгүй хэрэгжүүлье.

Ургац хураалт, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл ид явагдаж байна. Ургацын урьдчилсан балансыг өмнөх жилтэй харьцуулахад 1.2-1.8 дахин их үр тариа, төмс, хүнсний ногоо хураан авч 1.0 сая тонноос дээш хадлан авах боломжтой гэж гарсан. Гэвч энэ намрын цаг агаар тааламжгүй нөлөөлж мэдэхээр боллоо. Ирэх өвөл амаргүй болж магадгүйг манай малчид ардын ухаан, ажиглалт тандалтынхаа дагуу сануулж байна. Тиймээс намрын ургац хураалт, өвлийн бэлтгэлийг чамбай хийх, болзошгүй эрсдэлд бэлэн байх боломж нөөцийг одооноос бүрдүүлэх нь чухал байна.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы завсарлагааны хугацаанд нэр бүхий гишүүдээс ээлжит бус чуулган зарлан хуралдуулах шаардлага, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гишүүдийн шаардлагыг дэмжсэн саналыг ирүүлсэн. Товчхондоо ээлжит бус чуулганаар Авлигатай тэмцэх газрын даргыг томилсон Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгох санал тавьсан.

Авлигын эсрэг хуулиар Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг чөлөөлөх, огцруулах тодорхой үндэслэлийг хуульчлан заагаад, хуульд зааснаас бусад үндэслэлээр чөлөөлөх, огцруулахыг хориглосон байдаг.

Зөвхөн Авлигатай тэмцэх газрын даргыг ч биш, төрийн аль ч шатны, ямар ч албан тушаалтныг зөвхөн хуульд заасан үндэслэлээр л албан тушаалаас нь чөлөөлж, огцруулдаг эрх зүйн орчинд бид ажиллаж, амьдарч байгаа. Ийм байхад хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага баталсан хуулиа өөрөө зөрчдөг байж боломгүй.


Өнгөрсөн хугацаанд уг саналыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр хоёр удаа хэлэлцүүлсэн. Зөвлөлөөс хуулийн үндэслэлийг нь Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлсэний дараа ээлжит бус чуулганы товыг тогтоох нь зүйтэй гэж шийдвэрлэснийг хэлье.

Чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн хууль, тогтоолын төслүүдээ хугацаанд нь хэлэлцэн батлахад идэвх чармайлт гаргаж ажиллахыг гишүүд Та бүхнээс хүсье.

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.




Улсын Их Хурлын намрын чуулганы нээлтийн ажиллагаа




Япон Улсын парламентын Зөвлөхүүдийн танхимын дэд дарга Акира Гүнжи манай улсад айлчлах үеэрээ Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхлаа. Уулзалт бараалхалтад УИХ-ын дэд дарга, УИХ дахь Монгол-Японы парламентын бүлгийн дэд дарга Л.Энх-Амгалан, УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Масато Такаока, Зөвлөхүүдийн танхимын гишүүн Наоки Окада, Мамото Нишида, Казуяа Шимба, Рэнхо Мурата, Тадаёши Ичида нар байлцав. 2018.10.02




Манай улсад албан ёсоор айлчилсан ОХУ-ын Батлан хамгаалахын сайд, армийн генерал, ОХУ-ын баатар Сергей Кузугетович Шойгу-г Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын зарлигаар Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасан билээ. Шагналыг Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд гардуулж, баяр хүргэсний дараа Хүндэт зочинтой уулзаж ярилцав. 2018.10.18



Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд ХКН-ын Төв хорооны Улс төрийн товчооны Байнгын хорооны гишүүн, Тяньжин хотын Намын хорооны нарийн бичгийн дарга Ли Хунжуньг хүлээн авч уулзав. 2018.10.22



Монгол Улсын Их Хурлын даргаар сонгогдсон УИХ-ын гишүүн Г.Занданишарт УИХ-ын гишүүн М.Энхболд ажлаа албан ёсоор хүлээлгэн өгч, хүндэтгэл илэрхийллээ. 2019.02.01



Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданишатар БНКаЗУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Калыбек Ибрагимович Кобландинийг хүлээн авч уулзав. Элчин сайд К.Кобландин тус улсын парламент Мажилисийн тэргүүн Нурлан Ныгматулиний баяр хүргэсэн мэндчилгээг, Астанад болох Евразийн орнуудын парламентын спикерүүдийн IV зөвлөлдөх уулзалтад оролцох урилгын хамт УИХ-ын дарга Г.Занданишарт гардуулсан юм. 2019.02.15



Монгол Улсын Их Хурлын дэд дарга, УИХ дахь Монгол-Оросын парламентын бүлгийн дарга Л.Энх-Амгалан ОХУ-ын Холбооны хурлын Холбооны зөвлөлийн Үндсэн хуулийн эрх зүй, төрийн байгуулалтын хорооны дарга Андрей Александрович Клишас тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2018.11.19



Монгол Улсын Их Хурлын дэд дарга, УИХ дахь Монгол-Хятадын парламентын бүлгийн дарга Я.Санжмятав БНХАУ-ын Хайнань мужийн Улс төрөөр зөвлөлдөх зөвлөлийн орлогч дарга Ван Юн тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. 2018.12.21

НЭГ

ҮЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ
ҮЙЛ АЖИЛААГАА

НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТОЙМ

ХУРАЛДСАН ӨДӨР, ТОО

2018.10.01-2019.02.02 ДУУСТАЛ



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ



- Бие даасан хууль - **5**
- Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль - **25**
- Хүчингүй болсонд тооцох тухай хууль - **3**
- Гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль - **13**
- Улсын Их Хурлын тогтоол - **41**

УИХ-ЫН ГИШҮҮД АЖЛЫН

ХЭСГЭЭС АСУУСАН



АСУУЛТ, ХАРИУЛТ **640**

УИХ-ЫН ГИШҮҮД ҮГ ХЭЛСЭН

499 удаа,

36 цаг 13 минут



ТӨРИЙН ОРДОНТОЙ
ТАНИЛЦСАН ИРГЭД

3450



2018.10 сар: 9 удаа 43 цаг 42 минут
2018.11 сар: 11 удаа 27 цаг 02 минут
2018.12 сар: 1 удаа 3 цаг 23 минут
2019.01 сар: 8 удаа 36 цаг 09 минут
2019.02 сар: 2 удаа 10 цаг 50 минут

- Чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар нийт **249** хуудас товч тэмдэглэлийг хөтөлж, **2119** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулгав.
- Байнгын хороодын **83** удаагийн, **105** цаг **42** минутын хуралдааны явцын талаар **334** хуудас товч тэмдэглэл хөтөлж, **1788** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.
- Дэд хороодын **8** удаагийн, **12** цаг **43** минутын хуралдааны явцын талаар **26** хуудас гар тэмдэглэл хөтөлж, **189** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.
- Түр хорооны **1** удаагийн, **35** минутын хуралдааны явцын талаар **2** хуудас товч тэмдэглэл хөтөлж, **11** хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэв.



Улсын Их Хурлын намрын чуулганы нэгдсэн хуралдааны үеэр



Улсын Их Хурлын намрын чуулганы хаалтын ажиллагаа



Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг



Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг

ХОЁР

ҮЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН
ДЭД ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД, ТҮР ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Байнгын хороодын үйл ажиллагааны талаарх мэдээлэл



ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Байнгын хорооны **143** санал, дүгнэлт, танилцуулга бэлтгэн, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан шийдвэрлүүлжээ.



Байнгын хороонд иргэд **405** өргөдөл, байгууллага, аж ахуйн нэгжээс **574** санал хүсэлт ирснийг шийдвэрлэж, **427** албан бичигт хариу өгөв.

БАЙНГЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

(2019 оны 01 сарын 30-ны өдрийн байдлаар)

№	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Нийгмийн бодлого, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Өргөдлийн байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо
1	О.Содбилэг	Л.Элдэв-Очир	Ё.Баатарбилэг	М.Оюунчимэг	Д.Лүндээжанцан	Б.Чойжилсүрэн	Ш.Раднаасэд	Д.Дамба-Очир
2	О.Баасанхүү	Б.Бат-Эрдэнэ	О.Баасанхүү	М.Билэгт	О.Баасанхүү	Ж.Батзандан	О.Батнасан	Б.Баттөмөр
3	С.Батболд	Х.Болорчулуун	Ц.Мөнх-Оргил	Ц.Гарамжав	Ж.Батзандан	О.Батнасан	С.Бямбацогт	Ж.Бат-Эрдэнэ
4	Б.Бат-Эрдэнэ	Ц.Гарамжав	М.Билэгт	Д.Дамба-Очир	С.Бямбацогт	Б.Баттөмөр	Л.Болд	Л.Болд
5	Л.Болд	С.Жавхлан	Д.Ганболд	Г.Занданшатар	Б.Жавхлан	Ц.Даваасүрэн	Ж.Ганбаатар	Х.Болорчулуун
6	Х.Баделхан	Л.Мөнхбаатар	Г.Мөнхцэцэг	Д.Мурат	Г.Занданшатар	Ж.Мөнхбат	Д.Ганболд	Ж.Ганбаатар
7	Д.Лүндээжанцан	Г.Мөнхцэцэг	Н.Номтойбаяр	Ё.Баатарбилэг	Н.Амарзаяа	З.Нарантуяа	Ц.Гарамжав	Т.Аюурсайхан
8	Б.Наранхүү	Д.Мурат	М.Оюунчимэг	Б.Пүрэвдорж	Ж.Мөнхбат	Б.Наранхүү	Б.Дэлгэрсайхан	Б.Дэлгэрсайхан
9	Х.Нямбаатар	Я.Санжмятав	Л.Оюун-Эрдэнэ	Ш.Раднаасэд	Б.Наранхүү	Ц.Нямдорж	Л.Мөнхбаатар	Б.Жавхлан
10	Н.Номтойбаяр	Б.Саранчимэг	Я.Санжмятав	Д.Сарангэрэл	Л.Оюун-Эрдэнэ	Д.Оюунхорол	Ц.Мөнх-Оргил	З.Нарантуяа
11	Н.Оюундарь	Я.Содбаатар	Д.Сарангэрэл	Г.Солтан	О.Содбилэг	Ш.Раднаасэд	Х.Нямбаатар	М.Оюунчимэг
12	Оюунхорол	Г.Солтан	Б.Саранчимэг	А.Сүхбат	Д.Сумьяабаазар	Д.Тогтохсүрэн	Ц.Нямдорж	Д.Тэрбишдава
13	Л.Оюун-Эрдэнэ	А.Сүхбат	Б.Ундармаа	Д.Тогтохсүрэн	Д.Тогтохсүрэн	Ч.Улаан	Н.Оюундарь	Б.Ундармаа
14	Я.Санжмятав	Г.Тэмүүлэн	А.Ундраа	Н.Цэрэнбат	Д.Хаянхярваа	Ч.Хүрэлбаатар	Б.Пүрэвдорж	Я.Содбаатар
15	Т.Аюурсайхан	Д.Тэрбишдава	Н.Учрал	Б.Энх-Амгалан	Н.Цэрэнбат	Н.Амарзаяа	Ж.Батзандан	С.Чинзориг
16	А.Ундраа	Д.Цогтбаатар	Ц.Цогзолмаа	Л.Энхболд	М.Энхболд	Г.Тэмүүлэн	Н.Учрал	Б.Чойжилсүрэн
17	Б.Энх-Амгалан	Б.Батзориг	С.Чинзориг	Л.Энхболд	Н.Энхболд	Ө.Энхтүвшин	Л.Энхболд	Л.Элдэв-Очир
18	Ж.Энхбаяр	Ж.Энхбаяр	Л.Энх-Амгалан	Д.Эрдэнэбат	Д.Эрдэнэбат	С.Эрдэнэ	С.Эрдэнэ	Л.Энх-Амгалан
19	Н.Энхболд	Д.Эрдэнэбат	С.Эрдэнэ	Ж.Эрдэнэбат	Ж.Эрдэнэбат	Ж.Эрдэнэбат	Ж.Эрдэнэбат	Д.Эрдэнэбат

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

(2018.08.13-ны өдрийн байдлаар)

№	Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
	Тусгай хяналтын дэд хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо	Хүний эрхийн дэд хороо	Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо	Сонгогчийн нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо
1	С.Батболд	С.Бямбацогт	Б.Жавхлан	Ц.Нямдорж	З.Нарантуяа	Н.Оюундарь	Ж.Ганбаатар	А.Ундраа	О.Содбилэг	А.Сүхбат
2	Л.Болд	Х.Баделхан	Н.Амарзаяа	Д.Лүндээжанцан	Н.Амарзаяа	Ж.Батзандан	Т.Аюурсайхан	Е.Баатарбилэг	Н.Амарзаяа	Б.Батзориг
3	Н.Номтойбаяр	Л.Мөнхбаатар	О.Баасанхүү	Ч.Улаан	О.Батнасан	Л.Болд	Ж.Бат-Эрдэнэ	Д.Гантулга	Ж.Батзандан	Г.Мөнхцэцэг
4	Д.Оюунхорол	Б.Наранхүү	Ж.Мөнхбат	Н.Энхболд	Б.Баттөмөр	Д.Ганболд	Х.Болорчулуун	М.Оюунчимэг	Д.Сумьяабазар	Д.Мурат
5	Н.Энхболд	Д.Сарангэрэл	Б.Наранхүү	Ө.Энхтүвшин	Ц.Даваасүрэн	Б.Дэлгэрсайхан	Д.Дамба-Очир	Я.Санжмятав	Д.Хаянхярваа	Б.Саранчимэг
6	Б.Энх-Амгалан	Д.Тогтохсүрэн	Л.Оюун-Эрдэнэ		Б.Наранхүү	Б.Пүрэвдорж	З.Нарантуяа	Б.Саранчимэг	Н.Цэрэнбат	Я.Содбаатар
7	Я.Санжмятав	Г.Тэмүүлэн	Н.Цэрэнбат		Д.Тогтохсүрэн	Ш.Раднаасэд	С.Чинзориг	Ц.Цогзолмаа	Д.Эрдэнэбат	Г.Солтан
8		М.Энхболд	Д.Эрдэнэбат		Ч.Улаан	Н.Учрал	Л.Элдэв-Очир	С.Эрдэнэ		Д.Тэрбишдагва
9		Д.Эрдэнэбат			Ч.Хуралбаатар	Л.Энхболд		С.Чинзориг		Д.Эрдэнэбат
10										
				ХЗДХ-ийн сайд					АБГБХ-ны дарга болсон	

Нэг. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
О.СОДБИЛЭГ



19 ГИШҮҮН

7

удаа

ХУРАЛДААН

2

удаа

ТУСГАЙ ХЯНАЛТЫН ДЭД
ХОРОО ХУРАЛДСАН

АЖЛЫН ХЭСЭГ

2

удаа

БАЙГУУЛЖ

2

удаа

ХУРАЛДСАН
ТОО

- Хуулийн төсөл - **13**
- Улсын Их Хурлын тогтоолын төсөл - **1**
- Байнгын хорооны тогтоол - **2**
- Байнгын хорооны хуралдаанаас чиглэл, үүрэг өгсөн тэмдэглэл - **3**
- Зөвшилцөх асуудал - **4**
- Санал, дүгнэлт - **19**
- Танилцуулга - **14**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **75**

шийдвэрлэсэн албан бичиг **37**

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, гадаад бодлогын хэрэгжилтийг хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийн талаар болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлаар санал, дүгнэлт гаргах, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх, эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, үүрэг чиглэл өгөх, Улсын Их Хурлын гишүүд болон Байнгын хорооны гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд чиглэж ажиллалаа.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороо соёрхон батлах тухай 13 хууль хэлэлцэн Улсын Их Хурлаар батлууллаа.

Олон улсын гэрээ, хэлэлцээр, зээлийн хэлэлцээрийн төслийг тус Байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлт, хуралдааны тэмдэглэлийг Засгийн газарт хүргүүлсэн.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хийж, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

Хяналт, шалгалтын ажлын талаар:

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яамны 2018 оны үйл ажиллагааны тайлан, түүнчлэн холбогдох мэдээллийг авч Байнгын хорооны гишүүдэд хүргүүлж хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Байнгын хорооны ажлын хэсгийн гишүүд Дархан-Уул, Орхон аймгуудад байрлах Зэвсэгт хүчний анги байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа.

Бусад ажлын талаар:

Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын талаарх төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг эмхэтгэн товхимол болгон хэвлүүлж Байнгын хорооны гишүүд болон холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай лавлагааны эмхэтгэл (1992-2018 он) болон Элчин сайд томилох, зөвшилцөх асуудлыг өргөн мэдүүлсэн талаар болон эд мөрийн баримтын талаар, итгэмжлэл олгох тухай Улсын Их Хурлын даргын захирамжийн талаар, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох, консулын газар нээн ажиллуулах талаар тус тус хуулийн болон холбогдох бусад лавлагааг гаргасан.

Тайлангийн хугацаанд Байнгын хорооны ажлын албанаас Байнгын хорооны дарга болон гишүүдийн гадаад, дотоодын зочид төлөөлөгчидтэй хийх зургаан уулзалт, ярилцлагыг зохион байгууллаа. Тухайлбал, 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн гишүүн, Холбооны Батлан хамгаалахын сайд Урсула Фон Дер Лайен тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан.

Байнгын хорооны дарга 2018 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд АНУ-ын Хавай мужийн Хонолулу хотод зохион байгуулагдсан “Энэтхэг-Номхон далайн бүс нутагт баримтлах АНУ-ын стратегийн хэрэгжилт” сэдэвт олон улсын семинарт оролцов.

Түүнчлэн Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Улсын Их Хурлын Тамгын газраас хамтран зохион байгуулсан “Нийтийн сонголыг үр дүнтэй зохион байгуулах нь” сэдэвт сургалт, “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, “Хүний амь нас хохирсон хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг, Солонгосын хойгийн энх тайвны хамтын ажиллагааны талаарх семинарт Байнгын хорооны ажлын албаны ажилтнууд бүрэн хамрагдаж оролцсон.



Байнгын хорооны дарга О.Содбилэг, УИХ-ын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Германы парламентын бүлгийн дарга Д.Тэрбишдагва нар ХБНГУ-ын Бундестагийн гишүүн, Холбооны Батлан хамгаалахын сайд, доктор Урсула Фон Дер Лайеныг хүлээн авч уулзав. 2018.10.18



Байнгын хорооноос байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүд Зэвсэгт хүчний ангиудын тусгай хэрэгцээний газар, ангиудын үйл ажиллагаатай танилцах, хяналт шалгалт хийх зорилгоор Дархан-Уул, Орхон аймгуудад ажиллалаа. 2018.10.15-16

Хоёр. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО



БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Л.ЭЛДЭВ-ОЧИР



19 ГИШҮҮН

9
удаа **ХУРАЛДААН**

Хууль **5**

Улсын Их Хурлын
тогтоол **2** батлуулсан

- Хуулийн төсөл - **8**
- Улсын Их Хурлын тогтоолын төсөл - **1**
- Байнгын хорооны тогтоол - **3**
- Зарчмын зөрүүтэй санал - **14**
- Албан тушаалтныг томилох чөлөөлөх
- асуудал - **2**
- Харьяа байгууллагын тайлан - **3**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **49**
явуулсан албан бичиг **40**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2019 оны 01 дүгээр тогтоолоор байгуулсан Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хуралдсан.

Хууль, тогтоолын хэлэлцүүлгийн талаар:

Байнгын хороо УИХ-ын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хийж санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Мөн Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Ч.Улааныг томилох тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэж батлуулав.

Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах, Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахад үйл ажиллагаагаа чиглүүлэв.

Бусад ажлын талаар:

Байнгын хороо тайлант хугацаанд Ургац хураалтын явц, хэрэгжүүлж буй ажлын талаарх болон Мал тооллого, хадлан, тэжээл, ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажил, хүнсний ногооны хангамжийн талаарх Хүнс, хөдөө

аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын, Агаарын бохирдлыг бууруулах талаарх Улсын Их Хурлын болон Байнгын хороодын хамтарсан тогтоолын биелэлтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээллийг тус тус сонсч, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч цаашид эрчимжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг өглөө.

Мөн Байнгын хорооны гишүүд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн газар тариалангийн бүс нутагт очиж, хадлан, тэжээл, ургац хураалт, хүнсний ногооны хангамж, өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаад Монгол Улсын Засгийн газарт “Чиглэл өгөх тухай”, Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилгоор Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай, Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох тухай төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны гурван тогтоолыг баталсан.



Байнгын хороо Агаарын бохирдлыг бууруулах асуудлаар Ерөнхий хяналтын сонсголыг анх удаа зохион байгууллаа. 2019.01.30



Байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир Испани Улсын нийслэл Мадрид хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зохион байгуулсан Өлсгөлөн, шим тэжээлийн дутагдлын эсрэг дэлхийн парламентчдын чуулга уулзалтад оролцов. 2018.10.29-30



Байнгын хорооны гишүүд Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Зүүнбүрэн сумын газар тариалангийн бүс нутагт хадлан, тэжээл, хунсний ногооны хангамж, ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай танилцсан. 2018.10.19-21

Гурав. НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО



НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ё.БААТАРБИЛЭГ



19 ГИШҮҮН

12
удаа

ХУРАЛДААН

АЖЛЫН ХЭСЭГ

3

удаа

БАЙГУУЛЖ

11

удаа

ХУРАЛДСАН
ТОО

- Хуулийн төсөл - **8**
- Хяналт, шалгалтын тайлан - **5**
- Харьяа байгууллагын мэдээлэл - **5**
- Албан тушаалтныг томилох, чөлөөлөх - **2**
- Цэцийн дүгнэлт - **2**
- Санал, дүгнэлт - **13**
- Зарчмын зөрүүтэй санал - **42**



Хууль **5**

Улсын Их Хурлын
тогтоол батлуулсан **1**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **102**
явуулсан албан бичиг **87**

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 2018 оны хөрөнгө оруулалтын явц, гүйцэтгэлийн тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын мэдээллийг тус тус сонсож Засгийн газарт тэмдэглэлээр тодорхой чиглэл хүргүүлсэн. Монгол Улсын консерватор /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, “Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” зэрэг Байнгын хорооны зургаан тогтоолыг баталж, Байнгын хорооны тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр холбогдох байгууллагуудад зургаан удаа зөвлөмж, чиглэл өгч ажиллав.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

Мөн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус батлууллаа.

Түүнчлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бичил уурхай эрхлэгч иргэдийн талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол зэрэг нь хэлэлцүүлгийн шатанд, Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалтын тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн шатанд байна.

Хяналт, шалгалтын ажлын талаар:

Тайлангийн хугацаанд Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт, шалгалтын чиг үүрэг бүхий гурван ажлын хэсгийг байгуулж, холбогдох яам, харьяа газарт Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн

байдалтай танилцаж, биелэлтэд хяналт тавьж байгаа бөгөөд ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

а/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны 2018 оны хөрөнгө оруулалтын явц, гүйцэтгэл, үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газарт 2018, 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тодорхой чиглэлийг хүргүүллээ.

б/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг шалгах, соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж соёл урлагийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцэж Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Байнгын хорооны тогтоолыг баталсан.

в/Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганболд ахлан ажиллаж байна.

Бусад ажлын талаар:


Тус Байнгын хороо холбогдох яам, харьяа газартай хамтран есөн удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, сургалтуудыг зохион байгууллаа. Тухайлбал, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлаар ажил олгогч эзэд болон аж ахуйн нэгжүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг, Хөвсгөл аймгийн бүх багийн эмч нарыг хамруулсан “Багийн эмчийн яаралтай тусламж үзүүлэх цогц чадамж” сэдэвт сургалт, Хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалах тухай хуулийн төслийн танилцуулга, Улсын Их Хурал дахь “Сүрьеэгүй Монгол” лобби бүлэг, Эрүүл мэндийн яам, Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран “Сүрьеэгүй Ази тивийг бий болгох арга замыг хайх нь” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг тус тус зохион байгуулав.



Азийн Паралимпийн наадмын нээлтийн үеэр Байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг тэргүүтэй төлөөлөгчид Азийн Паралимпийн хорооны ерөнхийлөгч Мажид Рашидтай уулзав.
2018.10.10



Байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг МУИС болон АШУҮИС-ийн урилгаар манай улсад ажиллаж байгаа QS (Quacquarelli Symonds) байгууллагын Азийг хариуцсан гүйцэтгэх захирал, хатагтай Мэнди Мок-ыг хүлээн авч уулзлаа.
2018.11.05



Байнгын хорооны дарга, Улсын Их Хурал дахь “Сүрьеэгүй Монгол” лобби бүлгийн ахлагч Ё.Баатарбилэг БНСУ-ын Үндэсний сүрьеэгийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Кён Ман Ху тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзлаа.
2018.10.31



Байнгын хороо, Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүн амын сан хамтран Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа.
2018.11.14



Байнгын хорооноос “Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ, ДОХ-ын халдварын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.
2018.11.21



Байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч, хатагтай Наоми Китахараг нутаг буцаж байгаатай нь холбогдуулан хүлээн авч уулзав.
2019.01.09

Дөрөв. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО



ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



19 ГИШҮҮН

17
удаа

ХУРАЛДААН

АЖЛЫН ХЭСЭГ



- Хуулийн төсөл - **7**
- УИХ-ын тогтоолын төсөл - **22**
- Байнгын хорооны тогтоол - **5**
- Албан тушаалтныг томилох, чөлөөлөх - **11**
- Цэцийн дүгнэлт - **2**
- Санал, дүгнэлт - **36**
- Танилцуулга - **6**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **42**

явуулсан албан бичиг **42**

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрийн албаны тухай (Шинэчилсэн найруулга) хуульд заасны дагуу Улсын Их Хурлаас батлан гаргах дүрэм, журмыг боловсруулах, хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгүүд, Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийн төлөөлөл сонгон шалгаруулах комиссыг тус тус шинээр байгуулсан.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах, Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах, хуулийн дагуу холбогдох албан тушаалтныг чөлөөлж, томилох ажлыг хэрэгжүүлсэн.

Тус байнгын хороо хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3, хууль хүчингүй болгох тухай хуулийн төсөл 1, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 24-ийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулав.

Бусад ажлын талаар:

Тайлант хугацаанд Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн судлаачдын ажлын дэд хэсэг зургаан удаа хуралдаж Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар, үндэслэл, тайлбар боловсруулав.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал боловсруулсан.

3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлд давхардсан тоогоор нийт 54 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн боловсруулж, хуулиудын төслийн үр нөлөөний үнэлгээг боловсруулж, төслүүдийг өргөн мэдүүлэх бэлтгэл ханган ажиллаж байна.

4.Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг гурван удаа хуралдсан.

5. “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцангийн “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах үйл явц” сэдэвт илтгэл, “Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлага” олон улсын эрдэм шинжилгээний хуралд Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатарын хэлэлцүүлсэн “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ба зөвлөлдөх ардчилал” сэдэвт илтгэлийг боловсруулан бэлтгэсэн. Тус Байнгын хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн Хөгжлийн агентлагийн хамтарсан “Нутгийн удирдлагын тогтолцоо, эрх зүйн шинэчлэл” чуулганыг Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулсан.



Байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулав.

2018.10.25



Байнгын хорооны дарга Д.Лундээжанцан, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, Ц.Мөнх-Оргил нар Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн нийтийн сонголын зохион байгуулалтын талаар туршилага судаллаа. 2018. 12.17-18



Байнгын хорооны дарга Д.Лундээжанцан Оросын Холбооны Улсын Холбооны хурлын Холбооны зөвлөлийн Үндсэн хуулийн эрх зүй, төрийн байгуулалтын хорооны дарга Андрей Александрович Клишас тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзлаа. 2018.11.19

Тав. ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО



ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ЧОЙЖИЛСҮРЭН



19 ГИШҮҮН

10
удаа

ХУРАЛДААН

- Хууль - **11**
- УИХ-ын тогтоол - **9**
- Албан тушаалтныг томилох, чөлөөлөх - **2**
- Гэрээ, хэлэлцээр зөвшилцсөн - **2**
- Санал, дүгнэлт - **15**
- Байнгын хорооны тогтоол - **2**
- Зарчмын зөрүүтэй санал - **85**

АЖЛЫН ХЭСЭГ

3
удаа **БАЙГУУЛСАН**

7
удаа **ХУРАЛДСАН ТОО**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **91**

явуулсан албан бичиг **78**

Төсвийн байнгын хороо нь Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы тайлант хугацаанд Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулиуд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрүүд, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолыг хэлэлцэн батлах, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зарцуулалтыг шалгаж судлах Түр хороо байгуулах тухай, Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлэлцээрийг зөвшилцөх талаар санал, дүгнэлт гаргах чиглэлээр ажиллалаа.

Төсвийн байнгын хороо 10 удаа, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хоёр удаа хуралдаж, мөн хууль найм, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн болон дэд ажлын хэсгийн долоон удаагийн хуралдааныг зохион байгуулав.

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

2018 оны намрын чуулганы хугацаанд бие даасан хууль гурав, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай найман хууль, Улсын Их Хурлын тогтоол зургааг батлуулж, Олон улсын зээлийн хэлэлцээрийн хоёр төсөл зөвшилцсөн.

Бусад ажлын талаар:

Гадаадын зочид, төлөөлөгчидтэй гурван удаа уулзалт зохион байгуулж, тухай бүр тэмдэглэл хөтлөн ажиллалаа.

1.Улсын Их Хурлын Тамгын газрын 2019 оны төсвийн төслийг байнгын хороогоор хэлэлцэн баталсан.

2.Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны төсвийг байнгын хороогоор хэлэлцэн батлав.

3.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд болон зөвлөлийн даргыг томилох асуудлыг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн баталлаа.



Байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн Дэлхийн банкны Бээжинд суугаа Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн Хятад, Монгол, Солонгос Улсыг хариуцсан захирал ноён Берт Хофман тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.
2019.01.30



Байнгын хороо Татварын багц хуулийн төслийг танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулав.
2019.02.18

Зургаа. ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО



ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ш.РАДНААСЭД



18 ГИШҮҮН

13
удаа

ХУРАЛДААН

АЖЛЫН ХЭСЭГ



- Хуулийн төсөл - **12**
- Улсын Их Хурлын тогтоолын төсөл - **3**
- Харьяа байгууллагын тайлан - **2**
- Албан тушаалтныг томилох, чөлөөлөх - **6**
- Цэцийн дүгнэлт - **5**
- Санал, дүгнэлт - **17**
- Зарчмын зөрүүтэй санал - **10**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **29**

шийдвэрлэсэн харуу **15**

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар:

Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 07, 12, 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нотариатын тухай хуульд (шинэчилсэн найруулга) өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 12, 13, 15 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг тус тус хэлэлцэн батлуулав.

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10, 14 дүгээр дүгнэлт, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээлэл, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуульд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг, Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчийг танилцуулах тухай, Улсын Их Хурлын 5 гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлаар ирүүлсэн Улсын ерөнхий прокурорын санал, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, Өмгөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус хэлэлцлээ.

Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороонд, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж Төсвийн байнгын хороонд санал, дүгнэлтээ тус тус хүргүүлсэн.

Бусад ажлын талаар:

Хууль зүйн байнгын хороо “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам”, “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг тус тус зохион байгуулсан.

Мөн Байнгын хорооны ажлын албанаас “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг бэлтгэн хэвлүүллээ. Мөн 1993-2018 онд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хууль болон Улсын Их Хурлын тогтоолд тавьсан хоригийн талаарх судалгааг хийж, судалгааны санд оруулав.

Байнгын хороонд байгууллага, аж ахуйн нэгжээс 29 албан бичиг, иргэдээс 18 өргөдөл, гомдол ирж, асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж, хариуг өгсөн болно.



Байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль, Хил хамгаалах ерөнхий газар, Ханнс-Зайделейн сантай хамтран “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. 2018.10.11



Байнгын хорооны гишүүд Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас Монгол банк, Монголын банкны холбоотой хамтран зохион байгуулсан “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцлоо. 2018.10.30

Долоо. ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Д.ДАМБА-ОЧИР



19 ГИШҮҮН

13
удаа

ХУРАЛДААН

АЖЛЫН ХЭСЭГ

9

удаа

БАЙГУУЛСАН

34

удаа

ХУРАЛДСАН

ТОО

- Хууль - **11**
- Улсын Их Хурлын тогтоол - **6**
- Харьяа байгууллагын тайлан, мэдээлэл - **4**
- Албан тушаалтныг томилох, чөлөөлөх - **3**
- Гэрээ, хэлэлцээр зөвшилцөх - **1**
- Байнгын хорооны тогтоол - **11**
- Санал, дүгнэлт- **18**
- Зарчмын зөрүүтэй санал- **44**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ирсэн албан бичиг **97**

явуулсан албан бичиг **39**

2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Эдийн засгийн байнгын хорооны үйл ажиллагаа нь Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлох, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, Хэмжил зүйн тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүд болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Харилцаа холбооны тухай багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар санал, дүгнэлт гаргаж хэлэлцүүлэх, зарим салбарын сайд нарыг томилох, чөлөөлөх зэрэгт чиглэгдлээ.

Хууль тогтоох үйл ажиллагааны талаар:

Байнгын хороо давхардсан тоогоор 20 орчим асуудал хэлэлцэж, тэдгээр асуудлаар нийтдээ 18 санал дүгнэлт, танилцуулга бэлтгэн гаргаж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсний зэрэгцээ хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий есөн ажлын хэсэг байгуулан ажиллалаа.

Ээлжит чуулганы хугацаанд нийт дөрвөн тогтоолыг эцэслэн батлаж, Олон улсын нэг гэрээ, хэлэлцээрийн төслийг зөвшилцөв.

Мөн нэг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, хуулийн найман төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Бусад ажлын талаар:

Валютын ханш, бензин, шатахууны үнийн асуудлаар Засгийн газар, Монголбанкнд чиглэл өгөх шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, уг шийдвэрийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн батлав.

Ипотекийн зээл олголтын байдал, цаашид авах арга хэмжээний талаарх Барилга, хот байгуулалтын сайдын мэдээлэл сонссоны дагуу Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгөх тухай Байнгын хорооны шийдвэрийн төслийг боловсруулан баталж, Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох үүрэг, чиглэл өглөө.

Санхүүгийн зах зээлийн зөвлөл болон Олон улсын аудитын компани “Прайсуотерхаус Куперс аудит ХХК” (PWC)-тай хамтран “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх орчныг сайжруулах чиглэлээр хийж

байгаа алхмууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр Монголбанк, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгагчдын холбоо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, Монголын барилгын үндэсний ассоциаци болон арилжааны банкны төлөөллүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Монголбанктай хамтран “Макро эдийн засгийн бодлогын шинэ хандлагууд” сэдэвт хэлэлцүүлгийг Монголбанк болон арилжааны банкны төлөөлөл, эрдэмтэн, судлаачдыг оролцуулан зохион байгууллаа.

Алт олборлолтын байдал, цаашид авах арга хэмжээний тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын мэдээллийг сонсож, тулгамдсан асуудлуудаар үүрэг, чиглэл өгсөн.

Байнгын хороонд хандаж Төрийн болон бусад байгууллага, хуулийн этгээд, иргэдээс нийт 100 гаруй албан бичиг ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэн, хариуг холбогдох байгууллага, иргэдэд хүргүүлээ.



Байнгын хорооноос “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх орчин болон тэргүүлэх чиглэлийг сайжруулах өнөөгийн хүчин чармайлтыг хэлэлцэх нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. 2018.10.24



Байнгын хорооноос “Глобал орчин: Эдийн засгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. 2018.10.31

Найм. ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО



ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО

УИХ-ын 2018 оны намрын чуулганы хугацаанд



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
М.ОЮУНЧИМЭГ



17 ГИШҮҮН

2

удаа

ХУРАЛДААН

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ



- Хэлэлцсэн асуудал - **3**
- Байнгын хорооны тогтоол - **2**
- Зөвлөмж - **2**
- Хяналт шалгалтын тайлан - **1**
- Харьяа байгууллагын мэдээлэл - **1**

ТАЙЛАНТ ХУГАЦААНД

ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭСЭН ӨРГӨДӨЛ **316**
ШИЙДВЭРЛЭХ ШАТАНД **27**

Чуулганы хугацаанд Улсын Их Хуралд ирүүлсэн 24839 иргэний 518670 хуудас бүхий 3591 өргөдлийн 93 ботийг архивт хүлээлгэн өглөө.

Иргэдээс Улсын Их Хуралд өргөдөл гаргах боломжийг бүрдүүлэх, хөнгөвчлөх, төрийн байгууллагуудын өргөдөл шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, олон нийтэд нээлттэй, ил тод байх, иргэдээс өргөдөл шийдвэрлэлтийн ажиллагаанд хяналт тавих, олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг хийх боломжийг бүрдүүлсэн Өргөдлийн байнгын хорооны мэдээллийн удирдлагын систем буюу цахим хуудас, дотоод программ хангамжийн системийг хөгжүүлж байна. Байнгын хорооны үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон дараах цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд сурталчилж байна.

- urgudul.parliament.mn,
- www.facebook.com/Urgudliin.baingiin.khoroo,
- www.twitter.com/Urgudul1

Байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлын талаар:

Байнгын хороо 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 34, 35 дугаар байр, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Цагаан байрны оршин суугчдаас иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар ирүүлсэн өргөдлийг хэлэлцээд Засгийн газарт чиглэл өгөх тухай 07 дугаар тогтоолыг батлав.

Тогтоол хэрэгжсэнээр дээрх ашиглалтын шаардлага хангахгүй байранд оршин суугаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, байруудыг шинэчлэн барихад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Тус байнгын хороонд болон Улсын Их Хурлын дарга, гишүүдэд иргэд, төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Цэвэр агаар сан” болон 2008-2018 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгөөр хийгдсэн ажлуудын үр дүнгийн талаар Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа сонсов.

Мөн 2018 онд Дорноговь аймгийн Айраг, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл сум, Дундговь аймгийн Өлзийт, Хэнтий аймгийн Батширээт, Дэлгэрхаан, Ховд

аймгийн Мянгад сум, Төв аймгийн Угтаал цайдам, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, Нийслэлийн 7567 иргэн, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл зэрэг төрийн бус байгууллагаас байгаль орчин, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлаар өргөдөл ирүүлсний дагуу Байнгын хорооны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээллийг сонсов.

Түүнчлэн Өргөдлийн байнгын хорооныхон 05 дугаар тогтоолоороо Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгсний дагуу уг тогтоолын хэрэгжилттэй танилцахаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Нийслэлийн газрын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнууд, нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх Хараагүйчүүдийн хөдөлмөр, сургалт үйлдвэрлэлийн төв, цаасан тор, цаасан хайрцагны “Эко Пак Монгол” үйлдвэр, гялгар уут, торны “ОБ Пластик” ХХК зэрэг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, ажил хэргийн уулзалт хийж тодорхой асуудлуудаар үүрэг чиглэл өгсөн.

Хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан талаар:

Иргэдийн өргөдлийг судлах хүрээнд хариуцсан яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан дараах хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

Тухайлбал, Өргөдлийн байнгын хороонд иргэд /112/, төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн зарим заалт хэрэгжээгүй талаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас тайлбар, мэдээллийг сонсож, иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх, цаашид байр сууриа нэгтгэх зорилгоор 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт удааширсан тохиолдолд түүний шалтгаан, нөхцөлийг тодруулж, шуурхай арга хэмжээ авч байх, хуулийн биелэлтийг хангах ажлыг эрчимжүүлэх, хуулиар эрх олгосны дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын улсын бүртгэлд хяналт тавьж байх, ахуйн хаягдал усны төлбөрөөс иргэдийг чөлөөлөх, хөнгөлөх, эсхүл “0” хувиар оногдуулах, ус бохирдуулсны төлбөрийг тайлагнах асуудлыг судлан шийдвэрлэхийг Засгийн газарт, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төлбөрийн хэмжээний доод хязгаарыг 50-60 хувиар бууруулахаар тусгасныг нягтлан үзэх, түүнчлэн уул уурхайн компаниудын ус бохирдуулсны төлбөрийг тооцох, усны бохирдолтод тавих хяналт, химийн бодисыг цэвэрлэдэг цэвэрлэх байгууламжийн асуудлыг анхааралдаа авч, нарийвчлан судлахыг ажлын хэсэгт зөвлөв.



Байнгын хорооноос “Буянт Ухаа 2” хороололд барьж буй түрээсийн орон сууцны барилгын ажлын явцтай танилцахын зэрэгцээ холбогдох албан тушаалтнуудаас мэдээлэл авах үйл ажиллагааг зохион байгууллаа.

2018.12.04



Байнгын хорооны дарга М.Оюунчимэг тэргүүтэй албаны хүмүүс Нийслэлийн Чингэлтэй дүүргийн долдугаар хороонд байрладаг 173 дугаар цэцэрлэг, Сонгинохайрхан дүүргийн наймдугаар хороонд байрладаг 67 дугаар сургуулиудад очиж, ажиллалаа.

2018.12.12

Өргөдлийн байнгын хороо 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагналаа.

2019.02.12



ГУРАВ

ҮЛСЫН ИХ ХҮРЛЫН ХЯНАН ШАЛГАХ
ҮЙЛ АЖИЛААГАА

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД



УИХ-ын даргын захирамжаар

Туул голын сав газрын хамгаалалт, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах асуудлыг судалж шаардлагатай бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг газар дээр нь очиж танилцаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хамгаалалтад авах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулж Засгийн газарт хүргүүлсэн.

Үүний дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар Туул голын орчны бүсийг улсын тусгай хамгаалалтад авах, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төслийг эцэслэн боловсруулж Ерөнхий сайдад танилцуулахаар бэлтгэсэн байна.

УИХ-ын даргын захирамжаар

Улсын Их Хурал болон Байнгын хороо, дэд хорооноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр өгсөн тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг дүгнэх, шаардлагатай тохиолдолд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж, санал, дүгнэлт гарган Засгийн газарт чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна.

Тус ажлын хэсэг Улсын Их Хурлын даргын 2018 оны 02 дугаар тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хийсэн ажлын талаарх мэдээллийг сонсч, үйл ажиллагаагаа эрчимжүүлэхтэй холбогдуулан БОХХААБХ, НББСШУБХ-ны хамтарсан тогтоолоор Засгийн газарт холбогдох тогтоол, шийдвэрийг хүргүүлсэн бөгөөд үйл ажиллагаа үргэлжилж байна. БОХХААБХ-ноос зохион байгуулсан Ерөнхий хяналтын сонсголоор ажлын хэсгийн ахлагч Ё.Баатарбилэг ажлын хэсгээс хийсэн ажлын явц байдлын талаар мэдээлэл хийв.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг шалгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж, тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан удирдамж, төлөвлөгөөний төслийг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.

УИХ-ын даргын захирамжаар


Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ажилласан. Тус ажлын хэсэг батлагдсан удирдамжид заасан хугацаанд ажлаа хийж гүйцэтгэн дуусгаж, тайлан, нэгдсэн санал, дүгнэлтийн төслийг ажлын хэсгийн хүрээнд эцэслэн гаргаж, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

УИХ-ын даргын захирамжаар

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас баталгаа гаргаж, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын “Стандарт” банкнаас авсан зээл, түүнтэй холбоотой олон улсын шүүхийн байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн ахлагчийн баталсан хуваарийн дагуу удирдамжид заагдсан чиглэлүүдээр мэдээлэл, танилцуулга бэлтгэж байна. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.

3.2. Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, асуултын талаар

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад хандан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 26 гишүүн 77 асуудлаар 15 удаагийн асуулга тавьсан.



Чуулганы хугацаанд Улсын Их Хурлын таван гишүүн хамтран нэг асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж асуулт тавьсан.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн З.Нарантуяагаас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хийгдэх хяналт шинжилгээ, үнэлгээний талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төслийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, хөрөнгө оруулалт, үр дүнгийн талаар болон цаашид төслийн нэгжүүдийн үйл ажиллагааг үр дүнтэй, ил тод, хуулийн дагуу явуулах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатаас Ханшийн өсөлттэй холбогдуулж хийсэн интервенц, мөнгөний болон төсвийн бодлогын уялдаа, Засгийн газрын өрийн талаар тус тус Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан нийт 3 асуулгын хариуг сонссон.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу нэгдсэн хуралдаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 25 гишүүн 82 асуулт асууж, хариулт авч, санал хэлсэн байна.

/Дэлгэрэнгүйг "Мэдээ-1" хүснэгтээс үзнэ үү/

3.3. Монгол Улсын Ерөнхий сайдын нэгдсэн хуралдаанд хийсэн мэдээллийн талаар

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх нийгэм, олон нийтийн анхаарал татсан Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Авто замын салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, Мал аж ахуйн салбарт төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилт, бэлчээр ашиглалтын талаар нийт гурван удаа мэдээлэл хийв. Мэдээллийн үеэр Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн давхардсан тоогоор 11 гишүүн 47 асуулт асууж, хариулт авсан байна.

3

> **ЕРӨНХИЙ САЙДЫН
МЭДЭЭЛЭЛ УИХ-ЫН
НЭГДСЭН ХУРАЛДААНД**

19

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДИЙН
МЭДЭЭЛЭЛ БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНД**

Дэлгэрэнгүйг "Мэдээ-2" хүснэгтээс үзнэ үү!

Ээлжит чуулганы хугацаанд Байнгын болон дэд хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагын 19 удаагийн мэдээлэл, тайланг хэлэлцсэн бөгөөд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 125 гишүүн 325 асуулт асууж, хариулт авч, санал хэлжээ.

/Дэлгэрэнгүйг "Мэдээ-3" хүснэгтээс үзнэ үү!

Мэдээ-1

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС 2018 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД
ТАВЬСАН АСУУЛГЫН ТАЛААРХ МЭДЭЭ**

№	Улсын Их Хурлын гишүүний нэр	Хэнд, ямар байгууллагад хандаж тавьсан	Асуулгын агуулга	Хамрагдсан тоо	Албан бичгийн огноо				Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан			Тайлбар
					Хүргэсэн	Хариу ирүүлсэн	Хугацаа хэтэрсэн эсэх	Асуулгын хариуг сонсох гишүүний санал	Нэгдсэн хуралдаанд сонссон огноо	Асуулт тавьсан гишүүний тоо, асуулт		
1	О.Баасанхүү	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Эрдэнэтийн 51 хувийг барьцаалсан асуудлаар Лондонгийн Арбитрын шүүхийн шийдвэртэй холбоотой нөхцөл байдлын талаар	3	2018.08.06 №35	2018.10.02 ХЭГ/2128	45	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй	
2	Б.Энх-Амгалан	Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо	Төрийн алба мэргэжлийн болон ёс зүйн чадавхтай байх, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх бололцоог хангахад Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй ажлын талаар	7	2018.08.17 №36	2018.09.17 №965	-	2018.10.04 11239	-	-	Хүлээгдэж байна	
3	Ж.Батзандан	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	БНТУ-ын иргэн, "Улаанбаатар Эмпати" сургуулийн захиралтай холбоотой гүйцэтгэх ажиллагааны талаар	2	2018.08.27 №37	2018.10.03 ХЭГ/н-57	5	-	-	-	Нууцын журмаар хариу ирсэн	

4	С.Бямбацогт	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим зохицуулалт, гаднын орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд Монгол Улсын экспортын хэмжээг нэмэгдүүлж, аж ахуйн нэгжүүдийг дэмжиж чадаж байгаа эсэх талаар	5	2018.09.11 №38	2018.10.11 ХЭГ/2209	-	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
5	С.Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Монгол Улсын гадаад өр, бондын хөрөнгийн зарцуулалтын талаар	8	2018.09.14 №39	2018.10.11 ХЭГ/2208	-	2019.01.11 336	-	-	Хүлээгдэж байна
6	Б.Пүрэвдорж	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Хууль зөрчин Хөвсгөл аймгийн Засаг даргыг томилсон талаар	2	2018.09.25 №40	2018.10.23 ХЭГ/2333	-	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
7	Т.Аюурсайхан	Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж	Хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлах, худалдаалах гэмт хэргийг таслан зогсоох, түүнээс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын талаар	3	2018.10.01 №41	2018.11.01 1-1/5327	-	2018.11.06 12622	-	-	Хүлээгдэж байна
8	Л.Мөнхбаатар	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилт, байгалийн цогцолборт газарт газар ашиглуулах эрх олгоход баримталж байгаа бодлогын талаар	7	2018.10.02 №42	2018.11.13 01/8018	-	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй

9	Д. Эрдэнэбат	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Америк долларын ханшийн өсөлттэй холбогдуулж хийсэн интервенц, мөнгөний болон төсвийн бодлогын уялдаа, Засгийн газрын өрийн талаар	6	2018.10.02 №43	2018.11.02 ХЭГ/2413	-	2018.11.13 01/42	2019.01.25	8/31	Сонссон
10	Б. Жавхлан	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	"Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийг соёрхон баталсантай холбогдуулан Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар	5	2018.10.18 №44	2018.12.05 ХЭГ/2670	18	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
11	М. Билэгт Ж. Бат-Эрдэнэ Ж. Мөнхбат	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилтийн талаар	4	2018.10.18 №45	2018.11.17 ХЭГ/2507	2	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй
12	Ё. Баатарбилэг	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Үүрэн холбооны хэрэглээ, өнөөгийн байдал, технологийн шинэчлэлт, цахим орчны болон мэдээллийн аюулгүй байдлын талаар	8	2018.12.05 №46	2019.01.07 ХЭГ/50	3	-	-	-	Сонсох хүсэлт ирүүлээгүй

13	С.Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Өргөн хэрэглээний бараа, шатахуун, валютын ханшийн өсөлтийг тогтворжуулах, агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудаар Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ажлын талаар	7	2018.12.24 №47	2019.01.24 ХЭГ/207	1	-	-	-	-	Сонсох хусэлт ирүүлэггүй
14	Б.Пүрэвдорж	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Монгол Улсын төлбөрийн тэнцэл, нийт гадаад өр, төсвийн алдагдал, ханшийн хэлбэлзлийн талаар	5	2019.01.18 №01	-	-	-	-	-	-	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
15	Д.Оюунхорол Н.Амарзаа Г.Мөнхцэцэг З.Нарантуяа Н.Оюундарь М.Оюунчимэг Б.Саранчимэг Б.Ундармаа А.Ундраа Ц.Цогзолмаа	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	Монгол Улсын иргэдийн хорт хавдрын өвчлөлийн өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашид уг асуудлаар Засгийн газраас хэрэгжүүлэх ажлын талаар	5	2019.01.29 №03	-	-	-	-	-	-	Хариу ирүүлэх хугацаа болоогүй
			ДҮН-15	77	15	13	74	4	1		8/31	

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС 2018 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ТАВЬСАН
АСУУЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ**

№	Улсын Их Хурлын гишүүний нэр	Хэнд, ямар байгууллагад хандаж тавьсан	Асуултын агуулга	Хамрагдсан тоо	Албан бичгийн огноо			Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан			Тайлбар
					Хүргэсэн	Ирүүлсэн	Хугацаа хэтэрсэн эсэх	Асуулгын хариуг сонсох гишүүний санал	Нэгдсэн хуралдаанд сонссон огноо	Асуулт тавьсан гишүүний тоо, асуулт	
1	Л.Оюун-Эрдэнэ Т.Аюурсайхан Ж.Батзандан Л.Болд Х.Нямбаатар	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	“Эрдэнэт үйлдвэр” ХХК- ийн 49 хувийг эзэмшигч тал хувьцаагаа гадаадын компанид худалдаж байгаа гэх мэдээллийг шалгаж хариу ирүүлэх талаар	1	2019.01.25 №02	-	-	-	-	Хариу ирүүлэх хугацаа болоогүй	
ДҮН-1					1	1					

Мэдээ-2

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД СОНССОН
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ**

№	Сэдэв	Мэдээлэл хийсэн сайд	Мэдээллийг сонссон огноо	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүдийн тоо	Нийт асуулт, саналын тоо
1	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл	Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх	2018.10.05	4	21
2	Авто замын салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц	Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин	2018.10.19	4	12
3	Мал аж ахуйн салбарт төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилт, бэлчээр ашиглалтын талаар	Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин	2019.01.18	3	14
ДҮН - 3				11	47

Мэдээ-3

**2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАН**

№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүд /тоогоор/	Асуулт, саналын тоо
1	Эдийн засгийн байнгын хороо 2018.10.17	Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан	Валютын ханшийн өсөлт, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл	10	39
2	Эдийн засгийн байнгын хороо 2018.10.17	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар	Бензин, шатахууны үнийн өсөлт, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл	6	19
3	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.10.23	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг	Мал тооллого, хадлан, тэжээл, ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажил, хүнсний ногооны хангамжийн талаарх мэдээлэл	4	6
4	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.10.23	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	Агаарын бохирдлыг бууруулах талаар УИХ-ын болон Байнгын хороодын хамтран баталсан тогтоолын биелэлтийн талаарх мэдээлэл	8	30
5	Өргөдлийн байнгын хороо 2018.10.24	Барилга, хот байгуулалтын дэд сайд Ш.Лхамсүрэн, Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газрын дарга Ч.Батбилэг	Өргөдлийн байнгын хорооны 2018 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	5	23
6	Өргөдлийн байнгын хороо 2018.10.24	Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Одгэрэл	Үндэсний аудитын газраас 2018 онд “Цэвэр агаар сан”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан	9	35
7	Эдийн засгийн байнгын хороо 2018.10.30	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал	Алт олборлолтын явцын талаарх мэдээлэл	9	15
8	Хүний эрхийн дэд хороо 2018.11.14	Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж	Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн үндэсний комиссын 17 дахь илтгэл	11	24

9	Эдийн засгийн байнгын хороо 2018.11.13	Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан	Ипотекийн зээл олголтын байдал, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл	11	14
10	Өргөдлийн байнгын хороо 2018.12.05	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	УИХ-ын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Тусгай хамгаалалттай бүс нутгийн үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	4	8
11	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2018.12.11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Мөнгөнчимэг	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2017 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	10	25
12	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2018.12.18	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Хүүхдийн эрхийн тухай болон хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	5	8
13	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2018.12.25	Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Мөнгөнчимэг	Агаарын бохирдлын улмаас хүн амын дунд тохиолдож байгаа өвчлөл, эрүүл мэндийн асуудал, эрүүл мэндийн байгууллагын ачаалал, нөхцөл байдал, үүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл болон Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай хуулиуд, УИХ-ын 2018.01.05-ны өдрийн Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	14	36
14	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2019.01.08	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газраас чиглэл өгөх тухай НББСШУБХ-ны 2018 оны 06 сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	5	7

15	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2019.01.08	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	2018 оны төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээлэл	2	7
16	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2019.01.29	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газарт чиглэл өгөх тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	2	5
17	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2019.01.29	БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	4	8
18	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2019.01.29	БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа	Монгол Улсын консерватор /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	2	7
19	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2019.01.29	Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	Амьсгалын замын халдварт өвчин, томуу, томуу төст өвчинтэй холбогдуулан Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл	4	9
ДҮН-19				125	325

ДӨРӨВ

ҮЛСЫН ИХ ХҮРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДӨРӨВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1.Мэдээлэл, сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хууль тогтоох үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд бодитой, шуурхай, дэлгэрэнгүй мэдээлэл түгээн ажиллалаа.

БЭЛТГЭЖ ТҮГЭЭСЭН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

НИЙТ МЭДЭЭЛЭЛ 547



Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, гишүүд, Байнгын хороод, Тамгын газраас зохион байгуулсан хэвлэлийн хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх нийт 395 текст мэдээ бэлтгэн 1401 гэрэл зургийн хамт parliament.mn цахим хуудаст байршуулж, иргэдэд шуурхай түгээв. Түүнчлэн энэ хугацаанд Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга М.Энхболдын хэлсэн үг, Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэд дарга Акира Гүнжи Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболдод бараалхсан талаарх мэдээллийг англи хэл рүү хөрвүүлж, 17 фото нийтлэл бэлтгэж олон нийтэд хүргэлээ.

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын долоо хоног тутмын үйл ажиллагааг тоймлон хүргэдэг “УИХ - Энэ долоо хоногт” нэвтрүүлгийн 17 дугаар, Улсын Их Хурлаар хэлэлцэж буй хууль тогтоомжийн төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэх, хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн асуудлаарх Улсын Их Хурлын гишүүдийн байр суурийг олон нийтэд хүргэх “УИХ-ын гишүүнтэй ярилцах цаг” нэвтрүүлгийн дөрвөн дугаар, Үндсэн хуулийн өдөрт зориулсан “Үндсэн хууль” тусгай нэвтрүүлэг гурван дугаар, Парламентын тогтолцооны онцлог, түүний мөн чанар, Монголын парламентын түүхийг сурталчилсан “Парламентат ёс” нэвтрүүлэг нэг дугаарыг бэлтгэж [youtube.com](https://www.youtube.com), [facebook.com](https://www.facebook.com) цахим хуудаст байршуулсан.

Батлагдсан хууль тогтоомжийн талаар болон “Хуулиа дээдэлье” шторк долоон цуврал хийсэн болно. Түүнчлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүд, Улсын Их Хурлын дарга болон гишүүдийн уулзалт, Байнгын хороодоос зохион байгуулсан хэлэлцүүлэг, семинар, нээлттэй сонсгол болон тэмдэглэлт үйл явдал, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх 67 дүрст мэдээ бэлтгэж parliament.mn цахим хуудаст байршуулахын зэрэгцээ [twitter.com](https://www.twitter.com), [facebook.com](https://www.facebook.com) сүлжээгээр олон нийтэд түгээв.


Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороод, Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг, уулзалт, семинар, хэвлэлийн хуралд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулах ажлыг тухай бүрт нь зохион байгуулж ажиллалаа. Үүнд: Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагын зүгээс хийсэн 24 хэвлэлийн хурлыг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээллийг хүргэж, олон нийтэд түгээх ажлыг гүйцэтгэв.

“Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ” хэмээн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.10-г заасан бөгөөд ээлжит чуулганы хугацаанд “Төрийн мэдээлэл” хууль тогтоомжийн эмхэтгэлийн 17 дугаарыг бэлтгэн гаргаж захиалагч, уншигчдад хүргүүллээ.

Эмхэтгэлийн 17 дугаарт 40 хууль, Улсын Их Хурлын 23 тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 17 зарлиг, Засгийн газрын 21 тогтоол, Үндсэн хуулийн цэцийн есөн дүгнэлт, олон улсын гэрээ есийг нийтэлжээ.

Олон нийтийн сүлжээн дэх Улсын Их Хурлын албан ёсны хуудсуудаар хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг текст, фото, видео хэлбэрээр бэлтгэж олон нийтэд хүргэлээ. Өнөөдрийн

/2019.01.28/ байдлаар facebook.com цахим сүлжээн дэх Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсаар мэдээлэл хүлээн авах хэрэглэгчийн тоо 28,329 байгаа бол twitter.com сүлжээгээр мэдээлэл хүлээн авах хэрэглэгчийн тоо 26,718 болж нэмэгдсэн байна. Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд facebook.com, twitter.com олон нийтийн сүлжээн дэх албан ёсны хуудсаар нийт 547 мэдээ, мэдээллийг түгээгээд байна.



Олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүд болон иргэд, байгууллагаас ирүүлсэн 85 хүсэлтийн дагуу гадаад, дотоодын 3450 зочныг Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулав.

4.2. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт

2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодод ирсэн өргөдөл, хүсэлт, гомдлын мэдээллийг доорх зургаас харна уу.



Энэ хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо хамтран 1103 өргөдөл, гомдол буюу 64,3 хувийг бүрэн шийдвэрлэж, 629 буюу 36,7 хувь нь судалж, шийдвэрлэх шатандаа байна.

Иргэдээс ирүүлсэн 1715 өргөдлийн 1204 буюу 70,2 хувь нь нийслэлийн иргэдээс, 457 буюу 26,6 хувь нь хөдөө орон нутгийн иргэдээс /54 буюу 3,1 хувийн өргөдөл хаяг тодорхойгүй/ тус тус ирүүлсэн байна.

Иргэдийг хүлээн авах байраар нийт 422 иргэнийг биечлэн хүлээн авч уулзаж, санал, хүсэлтийг авснаас Улсын Их Хурлын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хэлэлцэж буй хууль тогтоомжийн төслүүдтэй холбогдсон болон нийтэд тулгарч буй асуудлын талаар 25 хүн саналаа илэрхийлж, 397 хүний тавьсан хувийн хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах нарт танилцуулан, зөвлөгөө өгөх, өргөдөл, гомдлын хариуг нь лавлах, шаардлагатай албан тушаалтантай нь холбогдож хариуг өгүүлэх зэргээр шийдвэрлэлээ.

4.3. Мэдээллийн технологи, техник ашиглалтын мэдээ

Хуралдааны цахим системийн үйлчилгээ

Программ хангамж:

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны цахим системийг ашиглан Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 31 удаагийн нийт 121 цаг 06 минутын нэгдсэн хуралдаанд 426 удаа санал хураалт явуулж, 1133 удаа гишүүдийн болон ажлын хэсгийн микрофоныг нээж, үг хэлэх, асуулт асуух, асуултад хариулах боломжийг олгосон.

Байнгын болон түр, дэд хороодын 92 удаагийн нийт 119 цаг 00 минутын хуралдаанд 514 удаа санал хураалт явуулж, 1661 удаа микрофон нээж ажиллуулсан байна.



Хуралдааны дүрсний систем:

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 31 удаагийн нэгдсэн хуралдаан, 92 удаагийн байнгын болон түр, дэд хороодын хуралдаан, 37 удаагийн Улсын Их Хурал дахь намын бүлгийн мэдээлэл, ажлын

хэсэг, сургалт семинар, мэдээллийн цаг, уулзалтын дүрс бичлэгийг хийсэн байна. Хуралдааны бүх дүрс бичлэгүүдийг хөрвүүлэн компьютерийн дотоод сүлжээний сервер компьютерт байршуулан хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаануудыг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн 2-р суваг, ТМ Телевиз, Сансар, Юнивишн, Скаймедиа кабелийн телевизүүд, Төрийн ордны теле сүлжээ болон www.parliament.mn цахим хуудсаар шууд дамжуулсан. Мөн ЗГХЭГ-аас зохион байгуулсан Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын нэгдсэн семинарыг Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, Төрийн ордны дотоод сүлжээний IPTV-гээр шууд дамжууллаа.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган болон Байнгын хороодын хуралдааныг шинээр нэвтрүүлсэн дотоод сүлжээний IPTV-гээр хэрэглэгчдэд шууд дамжуулан хүргэсэн.

Хуралдааны дууны систем:

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 31 удаагийн нэгдсэн хуралдаан, 92 удаагийн Байнгын болон түр, дэд хороодын хуралдаан, 135 удаагийн ажлын хэсэг, мэдээллийн цаг, сургалт семинар, уулзалтын дууны бичлэгийг хийсэн. Мөн хуралдааны дууны бичлэгүүдийг компьютерийн дотоод сүлжээний сервер компьютерт байрлуулан хуралдааны тэмдэглэл хөтлөгчид болон эрх бүхий бусад хэрэглэгчид ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Орчуулгын системийг намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа болон Улсын Их Хурлын Тамгын газраас нээлттэй сонсголын танхимд зохион байгуулсан хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээнүүдэд, зөөврийн хуралдааны системийг Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан өдөрт зориулсан шатрын тэмцээнд тус тус ашигласан.

Программ хангамжийн үйлчилгээ:

Хөдөлгөөнт оффисийн MyParliament системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, хууль тогтоогчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр шуурхай хангаж байна. Уг системд дараах мэдээ, мэдээллүүд шинээр нэмэгдэн орсон. Үүнд:


- системийн хандалт - 458
- үйл ажиллагаа - 1107
- хуулийн төсөл - 208
- хуулийн төслийн дагалдах файлууд - 600
- үйл явдал, хуралдаан - 259

Хэрэглэгчдийн компьютер, зөөврийн компьютерийн хэрэглээний хангамж /үйлдлийн систем, стандарт хэрэглээний программ/-ийн засвар үйлчилгээг 72 удаа гүйцэтгэж, хэрэглээний программын талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажилласан.

4.4. Судалгаа шинжилгээ, мэдээлэл, лавлагаа

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст Улсын Их Хурлын гишүүдийн санаачлан боловсруулж буй хуулийн төсөл болон Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах хууль, тогтоолын төсөлтэй холбоотой нийт 14 судалгааны захиалгыг Улсын Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагаас ирүүлсэн.

Судалгааны ангилал /төрлөөр/



Судалгааны ангилал /захиалагчаар/



Судалгааны дээрх ажлуудыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны албанд гүйцэтгэж, тайланг захиалагч гишүүдэд хүргүүлснээс гадна Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудын албан хэрэгцээнд зориулан Улсын Их Хурлын intra.parliament.mn дотоод сүлжээнд цахим хэлбэрээр, Улсын Их Хурлын Номын санд цахим болон хэвлэмэл хэлбэрээр тус тус байршуулсан.

Мөн Улсын Их Хурлын гишүүдийн хууль хэлэлцэн батлах үйл ажиллагаанд мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 оны Улсын Их хурлын намрын ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудад

холбогдох гадаад, дотоодын судалгааны байгууллага, судлаачдын гаргасан судалгаа шинжилгээний материал, өдөр тутмын хэвлэлийн нийтлэл, статистик тоо баримт зэрэг 180 нэгж мэдээлэл, материалыг цуглуулан мэдээллийн сан үүсгэж, хэлэлцэх асуудал тус бүрээр ангилан Улсын Их Хурлын *intra.parliament.mn* дотоод сүлжээ, хөдөлгөөнт оффисын *MUparl.mn* сүлжээнд тус тус байршуулсан.

Тайлант хугацаанд тус албанаас эрхлэн гаргадаг “Судалгааны эмхэтгэл” цувралын 27-р боть, “Судалгааны мэдээллийн сангийн лавлагаа” № 21, “Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга”, “Парламентын судалгааны албаны үйл ажиллагаа, эрх зүйн орчны гарын авлага” сэдэвт аргачилсан зөвлөмж зэрэг ном, товхимлуудыг гаргаж Улсын Их Хурал, Тамгын газар, олон нийтийн хэрэгцээнд хүргүүлээ.

4.5. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурал, Монголын Парламентын Бүлгэмийн түвшинд дараах дотоод болон гадаад арга хэмжээ, айлчлалууд хэрэгжсэн.

Дотоодод:

2018.10.01-04

Япон Улсын парламентын Зөвлөхүүдийн танхимын дэд дарга Акира Гүнжи тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав. Айлчлалын үеэр төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Улсын Их Хурлын дарга М.Энхболд нарт тус тус бараалхав. Бараалхах үеэр талууд хоёр улсын Стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа, тэр дундаа хоёр улсын хооронд байгуулагдсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих ажлууд, визийн асуудал зэрэг сэдвүүдийг хөндөн ярилцлаа. Мөн Японы тал 2020 оны Токиогийн олимпийг зохион байгуулах бэлтгэл ажлын талаар мэдээлэл өгч, 2025 онд Осака хотноо болох “Дэлхийн Экспо” үзэсгэлэнг зохион байгуулах Япон Улсын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхийг хүслээ.

2018.10.12

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Улс төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн Эдийн засгийн хорооны дэд дарга Юй Гуажоу тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчиллаа. Төлөөлөгчид айлчлалынхаа үеэр Улсын Их Хурлын гишүүн,

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Дамба-Очиртой уулзаж, Монгол, Хятад хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцаж, санал солилцов.

2018.11.19-21

Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн Үндсэн хуулийн эрх зүй ба төрийн байгуулалтын хорооны дарга Андрей Александрович Клишас тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав. Айлчлалын үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан нартай тус тус уулзалт хийж хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор Монгол Улсын Их Хурал, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Дум, Холбооны Зөвлөл хоорондын ойр дотно хамтын ажиллагааны талаар санал солилцов. Түүнчлэн энэ онд тохиох Халх голын ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах айлчлал, арга хэмжээ болон хоёр улсын харилцааны бэлгэ тэмдэг болсон томоохон бүтээн байгуулалтын ажлын талаар хөндөн ярилцлаа.

2018.12.21

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны Эдийн засгийн хорооны дэд дарга Ин Жунчин тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилсан. Айлчлалынхаа үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалантай уулзаж, хоёр улсын харилцааны тодорхой асуудлуудаар санал солилцов.

Мөн өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төвдийн Өөртөө Засах Орны Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дэд дарга Жу Жинхуа тэргүүтэй төлөөлөгчид Улсын Их Хурлын дэд дарга Я.Санжмятавт бараалхан нөхөрсөг уулзалт хийлээ.

Гадаадад:

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд УИХ-ын дарга, дэд дарга, Байнгын хорооны дарга, УИХ дахь парламентын бүлгэмийн давхардсан тоогоор 49 гишүүн гадаад орнуудад хэрэгжүүлсэн 55 арга хэмжээнд оролцов.

Тухайлбал, Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Г.Солтан нарын төлөөлөгчид 2018 оны 10 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их

Хурлаас Анталья хотноо зохион байгуулсан Евразийн орнуудын парламентын спикерүүдийн 3 дугаар чуулга уулзалтад, 2018 оны 10 дугаар сарын 14-19-ний өдрүүдэд Монгол Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, С.Бямбацогт, Б.Саранчимэг нар Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо болсон Олон Улсын Парламентын Холбоо /ОУПХ/-ны Ассамблейн 139 дүгээр чуулганд, 2019 оны 01 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ нар Камбож Улсын Сиэм Рэп хотноо зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын парламентын чуулганы 27 дугаар хуралдаанд тус тус оролцов.

Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Дамба-Очир Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнгийн хамт 2018 оны 10 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсад хийсэн айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж ажилласан бол Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Д.Ганболд нар 2018 оны 10 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд Индонез Улсад зохион байгуулагдсан Азийн паралимпын III наадамд, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Л.Энхболд нар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн олон улсад IPO гаргах бэлтгэл ажлын хүрээнд 2018 оны 10 дугаар сарын 08-14-ний өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улс болон Канад Улсад ажиллаж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Жавхлан, Ч.Улаан нар 2018 оны 10 дугаар сарын 11-17-ны өдрүүдэд Индонез Улсын Бали хотноо болсон Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн ээлжит чуулга уулзалтад оролцож, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, З.Нарантуяа, Б.Пүрэвдорж, С.Эрдэнэ нар 2018 оны 10 дугаар сарын 13-23-ны өдрүүдэд Унгар Улсад ажиллажээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Б.Болорчулуун, Л.Оюун-Эрдэнэ нар 2018 оны 10 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд Оросын Холбооны Улсад зохион байгуулагдсан Олон улсын парламентын гишүүдийн шатрын нөхөрсөг тоглолтод, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2018 оны 10 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсад зохион байгуулагдсан “Залуучуудын хөгжил” сэдэвт олон улсын чуулга уулзалтад, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга О.Содбилэг 2018 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын Хонулулу хотноо зохион байгуулсан “Энэтхэг-Номхон далайн бүс нутагт баримтлах Америкийн Нэгдсэн Улсын стратеги” сэдэвт дээд албан тушаалтнуудын олон улсын семинарт оролцсон бол Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа 2018 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд тус яамны шугамаар

Оросын Холбооны Улсын Эрхүү хотод, Улсын Их Хурлын гишүүн З.Нарантуяа 2018 оны 10 дугаар сарын 26-27-нд Оросын Холбооны Улсын Эрхүү хотод тус тус ажиллав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир 2018 оны 10 дугаар сарын 27-оос 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Испани Улсын Мадрид хотноо болсон Өлсгөлөн, шим тэжээлийн дутагдлын эсрэг дэлхийн парламентчдын чуулга уулзалтад, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа 2018 оны 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд Австрали Улсад зохион байгуулагдсан “Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн чуулга уулзалт 2018”-д, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан 2018 оны 11 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын Новосибирск хотноо болсон “Азийн уулзалтууд” 14 дүгээр чуулга уулзалтад оролцсон бол Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа 2018 оны 11 дүгээр сарын 18-26-ны өдрүүдэд тус яамны шугамаар Оросын Холбооны Улсад ажиллав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Б.Дэлгэрсайхан, Б.Саранчимэг нар 2018 оны 12 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж ажилласан бол Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Д.Эрдэнэбат нар 2018 оны 12 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн шугамаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн үйл ажиллагаа, нийтийн сонсгол зохион байгуулах туршлагатай танилцахаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар 2018 оны 12 дугаар сарын 20-28-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын Калифорни мужийн Сан-Франциско хотод зохиогдсон “Мэдээллийн технологи, аюулгүй байдал, хяналт” сэдэвт олон улсын хуралд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цогзолмаа 2019 оны 01 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хотноо зохиогдсон “Дэлхийн боловсролын сайд нарын чуулга уулзалт”-д тус тус оролцов.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Дамба-Очир 2018 оны 12 дугаар сарын 20-оос 2019 оны 01 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Тайланд Улсад, Улсын Их Хурлын гишүүн Б.Наранхүү 2019 оны 01 дүгээр сарын 10-аас 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд

Бүгд Найрамдах Сингапур Улсад, Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир 2019 оны 01 дүгээр сарын 14-өөс 02 дугаар сарын 20-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсад, Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва 2019 оны 01 дүгээр сарын 21-31-ний өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад тус тус ажилласан байна.

Монголын Парламентын Бүлгэм:

2018.10.29-11.02

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Британийн парламентын бүлгийн дарга С.Батболд тэргүүтэй төлөөлөгчид Британийн парламент дахь Британи-Монголын парламентын бүлгийн урилгаар Лондон хотноо ажлын айлчлал хийлээ. Бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын дэд дарга Я.Санжмятав, Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга М.Оюунчимэг, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар орж ажиллав.

2019.01.17-19

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн урилгаар Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга, Улсын Их Хурал дахь Монгол-Лаосын парламентын бүлгийн дарга Ё.Баатарбилэг тэргүүтэй Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд нарын төлөөлөгчид Лаос Улсад айлчиллаа.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА, ГИШҮҮДИЙН ГАДААД УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛ




Бүгд Найрамдах Турк Улсын Анталья хотноо болсон “Евроази дахь эдийн засгийн хамтын ажиллагаа, байгаль орчин, тогтвортой хөгжил” сэдэвт Евразийн орнуудын парламентын стикерүүдийн III чуулга уулзалтад УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан, УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан, Г.Солтан нар оролцов. 2018.10.08-10



Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо болсон Олон Улсын Парламентын Холбооны Ассамблейн 139 дүгээр чуулганд УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалан, УИХ-ын гишүүн Л.Болд, С.Бямбацогт, Б.Саранчимэг нар оролцлоо. 2018.10.14-19

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд, УИХ-ын гишүүн С.Эрдэнэ нар Камбожийн Хаант Улсын Сизм Рэл хотноо болсон Ази, Номхон далайн орнуудын парламентын чуулганы XXVII хуралдаанд оролцов. 2019.01.14-17



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төслийн удирдагч доктор (Sc.D), профессор Ц.Сарантуяаг хүлээн авч уулзав.

2018.11.12



Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон “Улсаа аврах ард түмний үндэсний хөдөлгөөн”, “Эрс шинэчлэл хөдөлгөөн”-ий тэргүүнүүдийг өөрсдийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзлаа.

2018.10.05



Тамгын газар, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Конгрессын Төлөөлөгчдийн Танхимын Ардчиллын түншлэл хамтран “Нийтийн сонсголыг үр дүнтэй зохион байгуулах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

2018.12.13



Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Ардын Их Хурлын депутатууд Төрийн ордноо хуран чууллаа.

2019.01.13



Тамгын газар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран “Нутгийн удирдлагын тогтолцоо-эрх зүйн шинэчлэл” сэдэвт чуулганыг зохион байгуулав.

2019.01.16

ТАВ

ХАВСРАЛТ

Хавсралт -1
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

Хавсралт -2
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, ТОГТООЛЫН
ТАНИЛЦУУЛГА

Хавсралт 1.**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР
БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ****2019.02.02****Нэг.Бие даасан хууль**

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (2018.10.25);
2. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай (2018.11.02);
3. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай (2018.11.02);
4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай (2018.11.02);
5. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай /Шинэчилсэн найруулга/, (2018.11.15).

Хоёр.Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

1. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.10.19);
2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.10.25);
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.02);
4. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.11.02);
5. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.02);
6. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.02);
7. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.11.02);
8. Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.11.02);
9. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.02);
10. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.02);
11. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);

12. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);
13. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);
14. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);
15. Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);
16. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);
17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);
18. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай (2018.11.15);
19. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2018.11.15);
20. Нотариатын тухай хууль (шинэчилсэн найруулга)-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (2019.01.17);
21. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2019.01.17);
22. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2019.01.18);
23. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2019.01.18);
24. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2019.01.18);
25. Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2019.02.02).

Гурав.Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль

1. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай (Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл” Зээлийн хэлэлцээр), (2018.10.11);
2. Конвенц соёрхон батлах тухай (Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1907 оны конвенц), (2018.10.11);
3. Хэлэлцээр соёрхон батлах тухай (Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хооронд 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр), (2018.10.11);

4. Хэлэлцээрт нэгдэн орох тухай (1979 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Швейцарийн Холбооны Улсын Женев хотод байгуулсан Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”), (2018.10.12);
 5. Хэлэлцээр соёрхон батлах тухай (Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн хооронд 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”), (2018.10.26);
 6. Гэрээ соёрхон батлах тухай (Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улс хооронд 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”), (2018.10.26);
 7. Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай (Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь-II төсөл”), (2018.10.26);
 8. Хэлэлцээр соёрхон батлах тухай (Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс хооронд 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээр”), (2018.10.26);
 9. Хэлэлцээр соёрхон батлах тухай (Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээр), (2018.11.15);
 10. “Иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ” соёрхон батлах тухай (2019.01.31);
 11. “Гэмт этгээдийг шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ” соёрхон батлах тухай (2019.01.31);
 12. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ” соёрхон батлах тухай (2019.01.31);
 13. “Мянганы сорилтын Компакт гэрээ” соёрхон батлах тухай (Гадаад харилцааны яамаар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар, Мянганы сорилтын Корпорациар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улсын хооронд байгуулсан), (2019.01.31).
-

Дөрөв.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль

1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (2018.10.19);
2. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2018.11.15);
3. Сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай /2019.01.17/.

Тав.Улсын Их Хурлын тогтоол

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх тухай (2018.10.04, дугаар 74);
2. Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай (2018.10.05, дугаар 75);
3. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай (2018.10.11, дугаар 76);
4. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 12 дугаар дүгнэлтийн тухай (2018.10.25, дугаар 77);
5. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай (2018.10.26, дугаар 78);
6. “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын зарим дэд заалт хүчингүй болсонд тооцох тухай (2018.11.02, дугаар 79);
7. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай (2018.11.02, дугаар 80);
8. Монгол Улсын Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай (2018.11.06, дугаар 81);
9. Б.Батзоригийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай (2018.11.07, дугаар 82);
10. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 13 дугаар дүгнэлтийн тухай (2018.11.15, дугаар 83);
11. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай (2018.11.15, дугаар 84);
12. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай (2018.11.22, дугаар 85)
13. Д.Хүрэлбаатарыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалаас нь түдгэлзүүлэх тухай (2018.11.22, дугаар 86);
14. Ерөнхийлөгчийн хоригийн тухай (2018.11.23, дугаар 87);

15. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 15 дугаар дүгнэлтийн тухай (2018.12.06, дугаар 88);
 16. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай (2018.12.06, дугаар 89);
 17. Б.Ундармаагийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай (2019.01.11, дугаар 01);
 18. Л.Энхболдын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай (2019.01.11, дугаар 02);
 19. Д.Дамба-Очирын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай (2019.01.11, дугаар 03);
 20. Г.Солтаны Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн тухай (2019.01.11, дугаар 04);
 21. Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай (2019.01.11, дугаар 05);
 22. Тогтоолын төсөл буцаах тухай (2019.01.17, дугаар 06);
 23. Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай (2019.01.17, дугаар 07);
 24. Тогтоолын төсөл буцаах тухай (2019.01.24, дугаар 08);
 25. М.Энхболдыг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай (2019.01.29, дугаар 09);
 26. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай (2019.02.01, дугаар 10);
 27. Г.Занданшатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай (2019.02.01, дугаар 11);
 28. Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай (2019.02.01, дугаар 12);
 29. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай (2019.02.01, дугаар 13);
 30. Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай (2019.02.01, дугаар 14);
 31. Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай (2019.02.01, дугаар 15);
 32. Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай (2019.02.01, дугаар 16);
 33. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм батлах тухай (2019.02.01, дугаар 17);
 34. Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай (2019.02.01, дугаар 18);
 35. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай (2019.02.01, дугаар 19);
-

36. Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам батлах тухай (2019.02.01, дугаар 20);
 37. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай (2019.02.01, дугаар 21);
 38. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах тухай өдрийг тогтоох тухай (2019.02.02, дугаар 22);
 39. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай (2019.02.02, дугаар 23);
 40. Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай (2019.02.02, дугаар 24);
 41. Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай (2019.02.02, дугаар 25).
-

Хавсралт 2.

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

А) Төрийн байгуулалтын болон хууль зүйн чиглэлээр:

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ХҮНИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР АЛБАДАН ЭМЧЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.11.15	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2018. 05.11-ний өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2019.01.01
----------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------



Хуулийн зорилт нь согтуурах, мансуурах донтой хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтан дор захиргааны журмаар албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах юм. Хууль 4 бүлэг, 23 зүйлтэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Улсын Их Хурлын 40 орчим гишүүн өнөөгийн Улсын Их Хурлын даргыг төрийн эрх барих дээд байгууллагыг удирдах ёс зүйн эрхгүй гэж үзэн, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-д заасны дагуу өөрийн хүсэлтээр ажил албан тушаалаасаа чөлөөлөгдөх шаардлага тавьсан, Улсын Их Хурлын дарга гишүүдийн тавьж буй шаардлагыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэн хүлээн авахаас татгалзсан, шаардлага тавьсан Улсын Их Хурлын гишүүд тухайн шаардлагыг нь Улсын Их Хурлын дарга хүлээн авч ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөөгүй тохиолдолд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд оролцохгүй гэдгээ илэрхийлсэн зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаа 40 гаруй хоногийн турш гацаж, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа тасалдаад байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааг гацаанаас гаргах, улс орны аюулгүй байдлыг сахин хамгаалах, Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтийг хангуулах шаардлагын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөлд Улсын Их Хурлын гишүүдийн олонх Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх тухай үндэслэл бүхий саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьж, тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн тохиолдолд нэн яаралтай журмаар хэлэлцүүлэх асуудал болон дагаж мөрдөх хугацааг тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын үйл ажиллагаа гацаанаас гарах, хүлээгдэж буй нийгэм, эдийн засгийн асуудлууд шийдвэрлэгдэх, хууль дээдлэх ёс бэхжих зэрэг эерэг үр дагавар үүснэ гэж хууль санаачлагч үзсэн болно.

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай Улсын Их Хурлын 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж Улсын Их Хурлаас 2018 оны 76 дугаар тогтоолыг батлан гаргасан. Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 03 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай 76 дугаар тогтоолыг хүчингүй болгосонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32¹ дүгээр зүйлд заасны дагуу Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Улсын Их Хурлын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар уг хуулийг баталсан.

Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэж үзсэн тул уг заалтыг Үндсэн хуулийн цэцийн тогтоолтой нийцүүлэх үүднээс “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал нь Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуульд нэр дэвших бол сонгууль товлон зарласан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор хүсэлтээ гаргаж, энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө төрийн албанаас болон ажлаасаа тус тус чөлөөлөгдсөн байна” гэж өөрчлөн найруулж, мөн 154 дүгээр зүйлийн 154.4 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал нь орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуульд нэр дэвших бол сонгууль товлон зарласан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор хүсэлтээ гаргаж, энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө төрийн албанаас болон ажлаасаа тус тус чөлөөлөгдсөн байна” гэж тус тус өөрчлөн найруулсан болно.

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 14 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.5 дахь заалтад заасны дагуу Сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар уг хуулийг баталсан.

Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэг, 160 дугаар зүйлийн 160.4 дэх хэсгийг тус тус Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэж үзсэн тул уг заалтыг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй нийцүүлэх үүднээс хүчингүй болгохоор хуульд тусгасан болно.

М.ЭНХБОЛДЫГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын нэр бүхий 39 гишүүн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хурлын дарга Миеэгомбын Энхболдыг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.3 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлаар нууц / цаасаар/ санал хураалт явуулж, Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас Улсын Их Хурлын гишүүн М.Энхболдыг чөлөөлөх шаардлагагүй гэж үзсэн.

Дээрх санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оруулсан бөгөөд санал хураалтыг нууцаар явуулж, Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх санал дэмжигдсэн тул М.Энхболдыг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлан гаргасан болно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ, “Г.ЗАНДАНШАТАРЫГ ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮН-МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Гомбожавын Занданшатарыг Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэх тухай саналыг 2019 оны Б/03 тоот албан бичгээр ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Улсын Их Хурлын тогтоол батлагдсантай холбогдуулан 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Их Хурлын даргаар сонгогдсон тул Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн Улсын Их Хурлын тогтоолыг баталсан.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ БҮТЦИЙГ
БАТЛАХ, ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

Улсын Их Хурал 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

2017 онд баталсан Төрийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн үзэл баримтлалын гол агуулга нь чадахуйн (мерит) зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэхэд орших бөгөөд үүнтэй холбоотойгоор Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэгт зарчмын шинжтэй өөрчлөлт орсон. Тус хуулийн 65 дугаар зүйлийн 65.3 дахь хэсэгт “Зөвлөл нь хараат бус, бие даасан байгууллага бөгөөд ажлын алба, салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна.” гэж тусгасан.

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсэгт “Зөвлөлийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг

Улсын Их Хурал тогтооно гэж заасан тул хуулийн шинэчлэлийн үзэл баримтлалд нийцүүлэн Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 70 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлах зайлшгүй шаардлага үүссэн.

Зөвлөл нь одоогийн орон тоогоор (19) шинэ хуулиар тогтоосон бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хүч боломж дутмаг байгаа тул түүний ажлын албаны орон тоог нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзсэн.

Тогтоолд Зөвлөлийн ажлын албаны зохион байгуулалтын үндсэн бүтцийг:

- 1.захиргаа, удирдлагын;
- 2.сонгон шалгаруулалтын;
- 3.хүний нөөцийн удирдлага, аудитын;

4.маргаан хянан шалгах нэгжтэй байхаар заасан ба эдгээрээс гадна салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийг байгуулж ажиллахыг Зөвлөлд зөвшөөрсөн ба Ажлын албаны орон тоо, түүний дээд хязгаарыг 56 албан хаагчтай байхаар тогтоосон.

Уг тогтоол батлагдсанаар Төрийн албаны зөвлөл Төрийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэнэ.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталснаар Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэгт зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орсон бөгөөд тэдгээрт нийцүүлж тус зөвлөлийн дүрмийг шинэчлэх шаардлага тавигдсан.

Энэхүү дүрэмд Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргийг чадахуйн зарчмыг хангуулахад нийцүүлэх, төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, хүний нөөцийн үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлэх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байдлаар явуулах зэрэг асуудлыг гол болгон анхаарч тусгасан болно.

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг шинэчлэн баталж мөрдүүлснээр Төрийн албаны зөвлөл бүрэн эрх, чиг үүргээ хараат бус, бие даасан байдлаар явуулж, төрийн албаны шинэчлэлийг үр нөлөөтэй, амжилттай хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдэнэ.

ТӨРИЙН ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталснаар Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 2009 оны 06 дугаар тогтоолоор баталсан ангилал, зэрэглэлийг уг хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх шаардлага тавигдсан.

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусган зарим байгууллагуудын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан тушаалын нэр өөрчлөгдсөнийг ангилал, зэрэглэлд нэмж, бүтцийн өөрчлөлтөөр хасагдсан албан тушаалыг ангилал зэрэглэлээс хасч, эдгээртэй холбогдсон зохих өөрчлөлтийг Улсын Их Хурлын тогтоолд тусгасан болно.

Энэхүү тогтоолыг баталж мөрдүүлснээр төрийн холбогдох байгууллагуудын албан тушаалын ангилал зэрэглэл Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийн үзэл санаа, зохицуулалтад нийцэж илүү тодорхой болох ба ингэснээр төрийн албан хаагчийн шатлан дэвших боломж, нөхцөл бүрдсэн.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталснаар Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Төрийн

захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам"-ыг уг хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх шаардлага тавигдсан.

Энэхүү тогтоолыг шинэчлэн батлахдаа “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын хүрээнд хуульд заасан тусгай шаардлагыг үндэслэн албан тушаалын зэрэг дэвийг шинээр олгох, ахиулан олгох, хэвээр хадгалах, олгохгүй байх, зэрэг дэвийг хэрэглэх харилцааг илүү тодотгосон бөгөөд зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг зэрэглэл хооронд 2 хувь байхаар нэмэгдүүлсэн болно.

Тогтоол батлагдсанаар төрийн захиргааны албан тушаалын тусгай шаардлага, тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг шалгуур болгон чадахуйн зарчимд үндэслэн шатлан дэвших тогтолцоог бүрдүүлэх боломж, нөхцөл бүрдсэн.

ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДАА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталснаар Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийг уг хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх шаардлага тавигдсан.

Уг тогтоолыг шинэчлэхдээ нэгэнт тогтсон одоогийн зэрэглэлийг үндсэнд нь хэвээр хадгалж, өмнөх тогтоолыг дагаж мөрдсөнөөс хойш шинээр бий болсон албан тушаалыг ангилал зэрэглэлд нэмэх, байхгүй болсон албан тушаалыг хасах аргачлалаар өөрчлөлт оруулсан болно.

Энэхүү тогтоол батлагдсанаар төрийн өндөр албан тушаалын ангилалд хамаарах албан хаагчдын зэрэг зиндаа илүү тодорхой болж, мерит зарчмыг баримтлан шатлан дэвших тогтолцоог хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдсэн.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ БОЛОН ТӨРИЙН АЛБАНД НЭР ДЭВШИГЧИЙН ЭРХ ЗӨРЧИГДСӨН ТУХАЙ МАРГААНЫГ ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталснаар тус хуульд томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд гарсан маргааны хүрээ, түүнийг хянан шийдвэрлэх харьяалалд зарчмын шинжтэй өөрчлөлт орсноор “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг шинэчлэх шаардлага тавигдсан.

Төрийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд энэ хуулийн 25, 26, 27, 45, 46, 47, 48 дугаар зүйл, 52.2, 66.1.11-д заасан асуудлаар гарсан маргаан болон төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргааныг хянан шийдвэрлэх журмыг нарийвчилсан.

Энэхүү тогтоол батлагдсанаар Төрийн албаны зөвлөл харьяаллын маргааныг хянан шийдвэрлэх, хууль бус захиргааны актыг хүчингүй болгох, төрийн албан хаагчийн зөрчигдсөн эрх ашгийг хамгаалах, хууль зөрчиж шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох бодит боломж, нөхцөл бүрдсэн.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ОРОН ТООНЫ ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хууль батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох болсон тул Төрийн албаны тухай хуулийн хуулийн 68 дугаар зүйлийн 68.2, 68.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас нэр дэвшүүлсэн Бадамцоогийн Идэрчулуун, Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах комиссоос сонгон шалгаруулсан Дорждамбын Зүмбэрэлхам, Должингийн Баатарсайхан нарыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилуулах санал ирүүлснийг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэгт “Улсын Их Хурал Зөвлөлийн гишүүнийг зургаан жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн гишүүнээр нэг удаа улируулан томилж болно” гэж заасны дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газрын санал болгосон Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоогийн бүрэн эрхийн хугацаа 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр дуусгавар болсон тул Улсын Их Хурлаас Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай тогтоолыг хэлэлцэн баталсан болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 42 ДУГААР ТОЙРОГТ НӨХӨН СОНГУУЛЬ ТОВЛОН ЗАРЛАХ, САНАЛ АВАХ ӨДРИЙГ ТОГТООХ ТУХАЙ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 42 ДУГААР ТОЙРОГТ НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛУУДЫН ТАНИЛЦУУЛГА

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг болон Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс товлон зарлаж, санал авах ажиллагааг 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдөр явуулахаар тогтоолоо.

2.Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын саналыг үндэслэн Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд 287 614 335 /хоёр зуун наян долоон сая зургаан зуун арван дөрвөн мянга гурван зуун гучин тав/ төгрөгийг Засгийн

газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэлээ. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай Улсын Их Хурлын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, тус Байнгын хорооны 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн тухай санал, дүгнэлтийг Улсын Их Хурал 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолд 30 хууль тогтоомжийн төслийг нэр заан тусгахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

1. Хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль тогтоомжийн төслүүд;
2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүдээс холбогдох Байнгын хороод эхний ээлжинд хэлэлцүүлэхээр саналаа ирүүлсэн төслүүд;
3. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд заасан болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тэргүүн ээлжинд хэлэлцэх хууль тогтоомжийн төслүүдийг хамруулах.

Энэхүү тогтоолоор хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолд нэр зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоосон. Мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын даргад зөвшөөрсөн болно.

Б) Төсөв, санхүүгийн чиглэлээр:**МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА****БАТАЛСАН
ОГНОО****2018.11.02****ХУУЛЬ САНААЧИЛСАН**Засгийн газраас
2018. 09.28-ны өдөр өргөн мэдүүлсэн**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА****2019.01.01****Нэг. МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР:**

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого **9,676.5 тэрбум** төгрөг буюу ДНБ-ий **27.4 хувь**, нийт зардал **11,589.1 тэрбум** төгрөг буюу ДНБ-ий **32.8 хувь** болж, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал **1,912.6 тэрбум** төгрөг буюу ДНБ-ий **5.4 хувь**тай тэнцүү байхаар батлагдлаа.

Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 11,067.0 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 322.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож баталсан нь өнгөрсөн оноос даруй 200.0 тэрбум төгрөгөөр илүү байна. Ирээдүйн өв санд 1,068.5 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн Хүний хөгжил сангийн үлдэгдэл өрийг төлж барагдуулснаар уг санд 550 гаруй тэрбум төгрөгийн хуримтлал үүсэхээр боллоо.

Улсын төсвийн орлого бүрдэлтийн хувьд татварын болон татварын бус орлогыг төрөл тус бүрд нь өнгөрсөн оноос харьцангуй өндөр байхаар тооцсон.

Тухайлбал:

- нэмэгдсэн өртгийн албан татвараас 2,321.1 тэрбум төгрөгийг
- аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 1,240.0 тэрбум төгрөгийг
- онцгой албан татвараас 837.8 тэрбум төгрөгийг
- гаалийн албан татвараас 743.0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэх юм.

2019 онд уул уурхайн салбарын орлогыг 2018 оны батлагдсан дүнгээс 1.3 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж тооцон нийт 3.0 их наяд төгрөгт хүрнэ гэж тооцож баталлаа.

Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлснээр ирэх онд 42 сая тонн нүүрс экспортолж, уул уурхайн салбарын голлох орлогыг бүрдүүлнэ гэж үзлээ.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 11,589.1 тэрбум төгрөгөөр, үүнээс урсгал зарлагыг 8,217.3 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 3,243.7 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнг 128.1 тэрбум төгрөгөөр тус тус баталсан.

Хавдар судлалын үндэсний төв, Улсын II нэгдсэн эмнэлгийг бие даан удирдлагаа хэрэгжүүлэхтэй холбоотойгоор татаас олгон, төсвөөс бүрэн гаргах нь зүйтэй гэж Засгийн газар шийдвэрлэж өргөн мэдүүлснийг цаг хугацааны хувьд эртэдсэн арга хэмжээ гэж үзэн буцааж улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Түүнчлэн орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын зориулалтаар улсын төсвөөс 189 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох, уг хөрөнгөөр аймаг, сумын төвийн шинэчлэл, зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн арга хэмжээнд зарцуулах, мөн орон нутгийн төсөвт байгууллагууд болон Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, тоног төхөөрөмж, албан хэрэгцээний автомашин худалдан авахад зарцуулахаар төсөлд тусгасныг төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсч болзошгүй тул улсын төсвөөс санхүүжүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэн, 180 тэрбум төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтад нэмж тусгасан болно.

Жилээс жилд хүчирхийлэлд өртөж, гэмт хэргийн хохирогч болж байгаа хүүхдүүдийн тоо нэмэгдэж, сургууль, гэр бүлийн орчинд эрх нь зөрчигдөж байгаа тул хүүхэд хамгааллын зардлыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж Улсын Их Хурал үзэж, уг зардлыг 5.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 8.0 тэрбум төгрөгт хүргэн баталсан.

Мөн ЖДҮ-ийг хөгжүүлэх санд мөнгө төлөвлөөгүй өргөн барьсан нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийг төрөөс дэмжих бодлоготойгоо уялдаагүй, хамгийн их ажлын байр бий болгодог салбарыг боомилсон, амьжиргааны гол эх үүсвэр болсон өрхийн орлогыг бууруулах бодлого гэж үзээд тус санд 47.0 тэрбум төгрөгийг тусган баталсан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт мөн тусгагдсан хүн амыг эрүүл хүнсээр хангах бодлоготой уялдсан “Мах, сүүний аян”-ыг дэмжиж 4.0 тэрбум төгрөгийг сүүний урамшуулал олгоход зориулан баталсан.

Цөлжилтийг сааруулах, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангах, ногоон эдийн засгийг дэмжих ажлыг эрчимжүүлэх үүднээс хатаж, ширгэх эрсдэлд орсон зарим нуур, цөөрмийг сэргээх ажлыг төсвөөс санхүүжүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 3,200.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1281 төсөл, арга хэмжээний 2019 онд санхүүжих дүнг 1,553.4 тэрбум төгрөгөөр баталлаа.

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ:

Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 161,002.2 сая төгрөгөөр батлав. Үүнд:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	10,752.9
2	Баян-Өлгий	6,798.2
3	Баянхонгор	15,858.0
4	Булган	1,310.4
5	Говь-Алтай	11,705.9
6	Дундговь	9,344.5
7	Завхан	14,482.4
8	Өвөрхангай	12,438.6
9	Сүхбаатар	7,918.5
10	Сэлэнгэ	5,461.8
11	Төв	6,786.5
12	Увс	21,383.1
13	Ховд	8,989.0
14	Хөвсгөл	16,775.3
15	Хэнтий	9,687.7
16	Говьсүмбэр	1,309.3
Нийт дүн		161,002.2

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 368,270.0 сая төгрөгөөр батлав. Үүнд:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ <i>/сая төгрөгөөр/</i>
1	Дорноговь	124.1
2	Дорнод	1,686.8
3	Өмнөговь	58,001.1
4	Дархан-Уул	3,010.2
5	Улаанбаатар	289,146.9
6	Орхон	16,300.9
Нийт дүн		368,270.0

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих зарлагын хэмжээг 2018 оноос 62 хувиар нэмэгдүүлж, 143,874.7 сая төгрөгөөр баталлаа.

Хоёр.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР:

Нийгмийн даатгалын санд 2019 оны төсвийн жилд 2,208,833.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталлаа.

Нийгмийн даатгалын сангаас зарцуулах зардлын хэмжээг 2,068,539.6 сая төгрөгөөр баталсан. Мөн Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 100,000.0 сая төгрөгөөр батлав.

Гурав.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР:

Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлогын хэмжээг 407,667.3 сая төгрөгөөр батлав. Эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулах зардлын хэмжээг 407,667.3 сая төгрөгөөр батлав.

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2020-2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО
2018.11.02**

ХУУЛЬ САНААЧИЛСАН
Засгийн газраас
2018. 09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**
Ердийн
журмаар

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2019 он	2020 он	2021 он
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.0	6.0
Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин /хувь/	8.0	8.0	8.0
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	9,676.5	10,713.5	11,844.7
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	27.4	26.4	26.4
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	11,589.8	12,393.6	12,901.1
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.8	30.6	28.7
Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,938.2	803.8	507.5
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.5	2.0	1.1
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,913.3	-1,680.1	-1,056.4
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-5.4	-4.1	-2.4
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,251.8	3,100.2	2,927.3
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	9.2	7.6	6.5
Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	19,551.6	19,390.8	18,383.6
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	55.3	47.8	41.0
Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	694.5	750.0	810.0
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	1.9	1.8

Гадаад, дотоод эдийн засгийн байдал, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн төлөв болон 2019 онд хэрэгжүүлэх гааль, татварын шинэчлэлийн бодлогын хүрээнд татварын бааз суурь өргөжин, төсвийн орлого нэмэгдэх, эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалтыг өсгөх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилтын хүрээнд тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин, хөлсийг нэмэгдүүлэх зэрэг бодлогын арга хэмжээтэй уялдуулан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг өөрчлөх нөхцөлийг бий болголоо.

2019 онд бодит эдийн засгийн өсөлт дотоодын нийт бүтээгдэхүүнээр тооцсоноор найман хувийн өсөлттэй байх бол 2020, 2021 онуудад зургаан хувь, харин хэрэглээний үнийн өсөлт найман хувьтай байна.

Ирэх гурван жилд баримтлах төсвийн бодлогыг тодотгон баталснаар гадаад, дотоод эдийн засгийн төлөв байдлын өөрчлөлттэй уялдуулан дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулан баталлаа. Түүнчлэн татварын бодлогод шинэчлэл хийх, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн хөрөнгө оруулалтын бодлогыг үргэлжлүүлэн явуулах, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэн иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэв.

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ БАТЛАГДСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2018.11.02

ХУУЛЬ САНААЧИЛСАН
Засгийн газраас
2018. 09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**
2019.01.01

Эдгээр хууль, тогтоолуудад дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг тусгасан.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг, хүүхдийн байгууллага, газар зохион байгуулалтын албаны байр ашиглалтын тогтмол зардал /халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түрээс, урсгал засвар үйлчилгээг/-ыг орон нутагт хариуцуулж, тухайн орон нутгийн суурь зардалд улсын төсвөөс нэмж шилжүүлэхээр зохицуулсан.

Соёлын болон нийтийн биеийн тамирын чиг үүргийг аймаг, нийслэлийн төсвөөр хэрэгжүүлэхээр шилжүүлж, орон нутгийн музей, соёлын төв, номын сан, театр, биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал (тогтмол болон хувьсах)-ыг орон нутгийн суурь зардалд шилжүүлэхээр хуульчилсан.

Мөн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 онд 50 хувийг, 2020 онд үлдэх 50 хувийг буюу нийтдээ 100 хувь тухайн хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн төсөвт, мөн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг 2020 оноос олборлолт явагдаж байгаа орон нутгийн төсөвт шилжүүлэх зохицуулалтыг тусгасан.

2.Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Засгийн газрын өрийг бууруулж, Монголбанкны балансын алдагдлыг багасгах зорилгоор Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн хэрэгжих хугацааг хоёр жилээр хойшлуулан, үүнтэй холбоотойгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулсан.

3.Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгаж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

4.Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар:

Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын болон нийтийн биеийн тамирын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж, санхүүжилтээ тусгай зориулалтын шилжүүлгээр авдаг байсныг өөрчлөн, соёл, урлаг, спортын чиг үүргийг орон нутагт бүрэн шилжүүлж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулсан.

5. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай, Улсын Их Хурлын тогтоолын зарим дэд заалт хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолоор:

2019 оны төсөвт цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх эх үүсвэрийг тусгасантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн “4/төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх; 5/төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах;” гэсэн заалтуудыг хүчингүй болгосон.

6. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолоор:

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан.

-улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллах;

-Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн дутагдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх;

-хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд зарцуулахаар баталсан хөрөнгийг хүүхэд хамгааллын чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг дэмжих, гэр бүлийн орчин, эрүүл мэнд, боловсрол, хэвлэл мэдээлэл, олон нийтийн үйл ажиллагаан дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ, урьдчилан сэргийлэх чиглэлээр зарцуулах;

-экспортод чиглэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг барьж байгуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд танилцуулах.

Мөн Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулан, төрийн үйлчилгээг орон нутагт саадгүй хүргэж, төсвийн үр ашиг, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөсөн.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХАМТ БАТЛАГДСАН ХУУЛИЙН ТАЛААР

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Дээрх хуулиудыг 2019 оноос хэрэгжүүлж эхэлснээр Нийгмийн даатгалын сангийн зарлага болон сангийн алдагдлыг нөхөх зорилгоор улсын төсвөөс олгох татаас их хэмжээгээр нэмэгдэхээр байгаа тул хуулиудын хэрэгжилтийг нэг жилээр хойшлуулж, 2020 оноос хэрэгжиж эхлэх зохицуулалтыг тусгасан.

“ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГИЙН ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлаас 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдээдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хууль болон хамт батлагдсан холбогдох бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолуудад Монгол Улсын Ерөнхийлөгч 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан юм.

Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцээд хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзэн Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталсан юм. Уг тогтоолыг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт тусгагдсан асуудал болох “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах экспортод чиглэсэн үйлдвэрүүдийг барьж байгуулахад шаардагдах 500.0 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилтийн эх үүсвэр”-ийг Төсвийн тухай хуулийн 34.1.4-т заасныг үндэслэн төсөвт тодотгол хийх замаар шийдвэрлэхийг дээрх тогтоолын 2 дахь заалтаар Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

В) Эдийн засгийн чиглэлээр:

**“ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**
2018.11.15

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018. 09.25-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд

Жилийн инфляци
2019-2020 онд



Дунд хугацаанд



Гадаад валютын улсын
нөөцийг нэмэгдүүлнэ



Санхүүгийн салбарын тогтвортой
байдлыг хадгалж, системийн
эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн
макро зохистой бодлогын арга
хэмжээг мөнгөний бодлоготой
хослуулан хэрэгжүүлнэ



Төв банкны олон нийттэй
харилцах үйл ажиллагааг
сайжруулж, бодлогын
нөлөөг дээшлүүлнэ



Санхүүгийн тогтвортой байдлын хүрээнд

Банк, санхүүгийн салбарын
хууль, эрхзүйн шинэтгэлийг
үргэлжлүүлнэ



Банкуудын өөрийн хөрөнгө,
төлбөрийн чадварыг сайжруулна



Олон улсад мөрдөгдөж байгаа
нягтлан бодох бүртгэл, хяналт
шалгалтын зарчим, зохицуулалтыг
эрчимтэй нэвтрүүлнэ



Харилцагчийн эрх ашгийг
хамгаалах зохицуулалтыг
боловсронгуй болгож,
хэрэгжилтэд хяналт шалгалт
хийх тогтолцоог сайжруулна



Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн хүрээнд

Үндэсний төлбөрийн системийн
найдвартай ажиллагааг
бэхжүүлж, төлбөрийн нэгдсэн
зохицуулалтыг бий болгоно



Олон нийтийн санхүүгийн суурь
мэдлэгийг дээшлүүлж, хамрах
хүрээг өргөжүүлнэ



Олон улсад мөрдөгдөж буй
тогтвортой санхүүжилтийн
нийтлэг зарчим, шилдэг
туршлагыг нэвтрүүлнэ



Технологийн дэвшил, шинэ
ололтыг нэвтрүүлэх замаар
үйлчилгээний хүртээмжийг
нэмэгдүүлж, өртөг зардлыг
бууруулж, аюулгүй, найдвартай
байдлыг хангасан дэд бүтцийг
хөгжүүлнэ



Нийгэм, боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.10.15

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018. 06.15-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2018.10.25



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



1 Малчнаар ажилласныг тодорхойлоход:



Мал, тэжээвэр амьтад, хашаа
худгийн тооллогын бүртгэл, лавлагаа;



Ажилласан жил, тэтгэврийн даатгалын
шимтгэлээ нөхөн тооцуулсан тухай баримт,
лавлагаа;



Иргэний үнэмлэхний хуулбар, эсхүл лавлагаа;

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ 2018.10.25-НЫ ӨДӨР БАТАЛЛАА.

2

Хөдөлмөрийн **ХОРТОЙ,**
ХҮНД нөхцөлөөр тэтгэвэр
тогтоох зохицуулалтыг
нэмж тусгалаа.



Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр орсон өөрчлөлтөөр малчдын өндөр насны тэтгэвэр тогтоох насыг 5 жилээр наашлуулан баталж, 2018 оноос хэрэгжүүлж байна.

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.10.19

ХУУЛЬ САНААЧИЛСАН

УИХ-ын гишүүн С.Бямбацогт,
Б.Дэлгэрсайхан, Ж.Энхбаяр,
Б.Энх-Амгалан нараас
2018.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2019.01.01



**“ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ” ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА:**



ХУУЛЬ БАТЛАГДСАНААР:



“Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60 сард хуваан тооцохоор болгон өөрчиллөө.”

ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГУУД:



**“Тэтгэвэр, тэтгэмжийн
хэмжээ буурахгүй”.**

2019.01.01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Хууль хэрэгжсэнээр тэтгэврээ тогтоолгох цэргийн алба хаагчаас гадна тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, онцгой байдал зэрэг байгууллагын алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурахгүй нийгэм, эрх зүйн баталгаа нь хэвээр хадгалагдах юм.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА****БАТАЛСАН
ОГНОО****2019.01.18****ХУУЛЬ САНААЧИЛСАН****Засгийн газраас
2018.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн****ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА****Ердийн
журмаар**

Улсын Их Хурлаас Эрүүл мэндийн тухай хуульд 2016 онд хийсэн нэмэлт, өөрчлөлтөөр “Тусгай эмнэлэг” (16.14.Тусгай эмнэлэг нь батлан хамгаалах, хууль сахиулах албаны албан хаагч, ял эдэлж байгаа ялтан, гэмт хэрэгт холбогдуулан шалгагдаж түр саатуулагдсан иргэнд эмнэлгийн анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна) гэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

Тусгай эмнэлэгт буюу зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн анги салбар, хилийн отряд дахь эмнэлэгт ажилладаг энгийн эмч, ажилтан, алба хаагчид нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллагсадтай нэгэн адил анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлдэг боловч Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаанд хамрагддаггүй байсан болно.

Иймээс Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг “Төрийн өмчийн эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх тусгай эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуульд заасан журмыг баримтлан тогтооно” гэж өөрчлөн найрууллаа.

Түүнчлэн дээрх хуулийн холбогдох хэсэгт “тусгай эмнэлэгт” тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн болон бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгох, 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа бол 5 жил тутамд улсын зардлаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах тухай өөрчлөлт оруулсан болно.

Д) Байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр:

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО
ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ, ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ТУХАЙ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.11.15

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.06.21-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

Эдгээр хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар мал аж ахуйн салбарын шинэчлэлийн бодлого, Улсын Их Хурлаас шинээр баталсан Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн зохицуулалт бусад хууль тогтоомжтой зөрчил үүсгэхгүйгээр хэрэгжих нөхцөл бүрдэнэ.


Хуулиудад орсон өөрчлөлт:



Е) Аюулгүй байдал, Олон улсын гэрээ, конвенцийн чиглэлээр

“УЛААНБААТАР ХОТЫН ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫГ БОЛОВСРУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАТАЛСАН ОГНОО 2018.10.11	ХУУЛЬ САНААЧИЛСАН Засгийн газраас 2018.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
----------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------



Зээлийн хэлэлцээрийн хүрээнд барилга болон барилга нураалтын хатуу хог хаягдлыг зөв зохистойгоор булж устгах, дахин боловсруулах шийдлүүдийг нэвтрүүлэх, түүнчлэн хатуу хог хаягдлын салбарт нэгдсэн тариф, удирдлагын зохицуулалтыг бий болгоход чиглэсэн “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас төслийг хэрэгжүүлэхэд 4.5 сая еврогийн буцалтгүй тусламж, 9.7 сая ам.долларын зээлийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газарт олгоно. Зээлийг 15 жилийн хугацаатай авч байгаа бөгөөд эхний 3 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Зээлийн жилийн хүү LIBOR+1 хувь бөгөөд энэ нь нэн хөнгөлөлттэй зээлийн ангилалд хамаарч байна.

ОЛОН УЛСЫН МАРГААНЫГ ЭНХИЙН ЗАМААР ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ 1907 ОНЫ КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО
2018.10.11**

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн
журмаар

АРБИТРЫН БАЙНГЫН ШҮҮХ



ОЛОН УЛСЫН МАРГААН ШИЙДВЭРЛЭДЭГ
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН БАЙГУУЛЛАГА



НИДЕРЛАНД УЛСЫН ГААГ ХОТНОО БАЙРЛАДАГ



121 УЛС ТУС БАЙГУУЛЛАГАД ГИШҮҮНЭЭР ЭЛССЭН

**МОНГОЛ УЛС
УГ КОНВЕНЦЫГ
СОЁРХОН
БАТАЛСНААР**



ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ,
ХЭЛЭЛЦЭЭРТЭЙ
ХОЛБООТОЙ
МАРГААНЫГ
ЗАРДАЛ БАГАТАЙ
ШИЙДВЭРЛҮҮЛЭХ

ТӨРИЙН АЛБАН
ХААГЧ, ХУУЛЬЧДЫГ
СУРГАХ

4 ХҮРТЭЛХ
ХҮНИЙГ
ШҮҮХИЙН
ГИШҮҮНЭЭР
6 ЖИЛИЙН
ХУГАЦААГААР
СОНГОХ

ГИШҮҮНЧЛЭЛИЙН
ТАТВАРТ ЖИЛ
БҮР 1071
ЕВРО ТӨЛНӨ

ШҮҮХИЙН ГИШҮҮНД
ТАВИГДАХ ШААРДЛАГА



ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН
АСУУДЛААР МЭРГЭШСЭН

ӨНДӨР ЁС СУРТАХУУНТАЙ
АРБИТРЧААР АЖИЛЛАХЫГ
ЗӨВШӨӨРСӨН

“ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮС МАКАО ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР” СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2018.10.11</p>	<p>ХУУЛЬ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2018.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
-----------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------

ХОЁР ТАЛТ ОЛОН УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭР



2018.10 сарын байдлаар Монгол Улсын 113 иргэн ял эдэлж байна.



Хэлэлцээрийг байгуулснаар

- Макаод ял эдэлж буй 12 иргэн эх орондоо ялаа эдлэх хууль, эрх зүйн үндэс бүрдэж,
- ар гэрийнхнийг нь сэтгэл санаа, эд материалын хувьд дэмжинэ.

Энэ хуулийн зорилт, хууль зүйн үндэслэл нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаод гэмт хэрэгт холбогдон хорих ял эдэлж буй Монгол Улсын иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, тэднийг эх оронд нь шилжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино. Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль нь 1 зүйлтэй.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т заасны дагуу Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хууль нь олон улсын хэлэлцээр тул Улсын Их Хурлаар соёрхон баталснаар хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛГИЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО
2018.10.12**

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.09.06-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**



Монгол Улс 1997 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Дэлхийн худалдааны байгууллагын 130 дахь гишүүн болсноор тус байгууллагын 164 оронтой нэн тааламжтай нөхцөлөөр худалдаа хийх, гишүүн орнуудын худалдааны бодлого, баримт бичгүүдийн мэдээллээр хангагдах, өөрийн улсын эрх ашгийг хамгаалах, техник туслалцааны хүрээнд дэмжлэг авах бололцоо бүрдсэн. Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр” нь 1980 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд 32 улс нэгдэн орсон байна. Энэхүү хэлэлцээрийн гол зорилго нь цэргийн зориулалтаас бусад иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон холбогдох тоног төхөөрөмжийн худалдаанд үүсч байгаа бэрхшээлийг арилгах, хэлэлцээрийн хавсралтад тусгасан тоног төхөөрөмж, эд ангийг гаалийн татвараас чөлөөлөх зохицуулалттай байна.

**“ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН
ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БНХАУ-ЫН ЗАСАГ
ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮС ХОНКОНГИЙН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.10.26

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.10.17-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн
журмаар



**2018.03.26-нд
Талууд гарын үсэг зурсан**



**2018.10.26-нд
Хэлэлцээр соёрхон батлах тухай
хуулийг баталсан**

Хэлэлцээрийг байгуулснаар:



**“ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ
КАЗАХСТАН УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ” СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2018.10.26

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.10.17-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн
журмаар




**2018.03.29-нд
Талууд гарын үсэг зурсан**



**2018.10.26-нд
Гэрээ соёрхон батлах тухай
хуулийг баталсан**




Гэрээг байгуулснаар:



**Эх орондоо ял эдлэхийг хүссэн хоёр
улсын иргэдийг шилжүүлэх
эрх зүйн орчин бүрдэнэ**



**Төрөлх хэл, соёл нэг, гэр бүл,
найз нөхөддөө ойр орчинд ял
эдлэх нь ялтны засрал,
хүмүүжилд зөргөөр нөлөөлнө**



**Тэдгээрийн гэр бүлд сэтгэл
санааны хувьд дэмжлэг болохын
зэрэгцээ зардал хэмнэнэ**




**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ
 GERMAN УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД БАЙГУУЛСАН “БИОЛОГИЙН
 ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД
 ДАСАН ЗОХИЦОХ НЬ - II ТӨСӨЛ”-ИЙН САНХҮҮГИЙН ХАМТЫН
 АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
 ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
 ОГНОО**
2018.10.26

ХУУЛЬ САНААЧИЛСАН
 Засгийн газраас
 2018.10.17-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
 ХУГАЦАА**
 Ердийн
 журмаар

ТӨСЛИЙН НИЙТ САНХҮҮЖИЛТ:
 24.25 сая евро



ТӨСЛИЙН ЗОРИЛГО



-Монгол орны БАРУУН болон БАРУУН ӨМНӨД бүс нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс тэдгээрийн менежментийг бэхжүүлэх



-Тухайн бүсийн ИРГЭД-ийн тогтвортой амьжиргааг дэмжих



-Ой, бэлчээр, аялал жуулчлал, биологийн олон янз байдлын загвар төслүүдийг хэрэгжүүлэх, суурь судалгаа хийх



ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААДАД:

-Сүлжээний тоног, төхөөрөмж нийлүүлэх



-Сургалт, мэдээлэл, хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчийн байр барих



-Судалгааны багаж хэрэгсэл, гал түймрийн тоног төхөөрөмж, хувцас, хэрэглэл бусад шаардлагатай хөрөнгө, оруулалт




“НИЙГМИЙН ХАМГААЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР” СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2018.10.26

ХУУЛЬ САНААЧИЛСАН
Засгийн газраас
2018.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**
Ердийн
журмаар



- Г** ШИМТЭЛ ТӨЛСӨН ДАВХЦААГИЙН ХУГАЦААТ НЭГТГЭН ТООЦНО
- Д** АР ГЭГТ ҮНЭ ТЭГЭМЖ ОЛГОХ БОЛСОНХ БҮРДЭЖ, ОРЛОГО БУУРАХ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАЛДАНА
- Е** НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛД САМУУЛЫН ДАРАМТ ҮҮСЭХГИ

- А** ТЭГЭВРИЙН ДААТГАЛЫН ХАРИЛЦАА ТАСРАХГИЙ
- Б** ТЭГЭВЭР АВАХ ЭРХ ҮҮСНЭ
- В** БАГА ХЭМЖЭЭНИЙ ТӨРӨГӨХ ЭРСДЭЛЭНИЙ ШИЙДВЭРЛЭНЭ

“НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР” СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2018.11.15

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн
журмаар

Аюулгүй байдал, гадаад
бодлогын байнгын хороо



Хууль батлагдаж,
Хэлэлцээр хэрэгжсэнээр

4 шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцно

5 нийгмийн баталгаа сайжирна


6 нийгмийн даатгалын санд санхүүгийн дарамт үүсэхгүй



2018.11.15-нд
хуулийг баталсан




НИЙГМИЙН ХАМГААЛАЛ



**ДААТГУУЛАХ
ХЭЛБЭР**

Албан журмын
Сайн дурын

Улсын Их Хурлын
Тамгын газар



Хууль батлагдаж,
Хэлэлцээр хэрэгжсэнээр

1 тэтгэврийн даатгалын харилцаа тасрахгүй

2 тэтгэвэр авах эрх үүснэ

3 бага хэмжээний тэтгэвэр авах эрсдэлийг шийдвэрлэнэ

“МЯНГАНЫ СОРИЛТЫН КОМПАКТ ГЭРЭЭ” СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2019.01.31

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**



Хууль батлагдсаны ач холбогдол

- 1** Ус хангамжийг нэмэгдүүлэх дэд бүтцийг байгуулах -Улаанбаатар хотын баруун чиглэлд ус хангамжийн дэд бүтцийг бий болгоно. -Ус цэвэршүүлэх байгууламж барина. -Шууун фабрик, Биокөмбинат чиглэлд 50 нэгж гүний худаг гаргана.
- 2** Ус дахин боловсруулах байгууламж барих -Ус дахин боловсруулах байгууламж барина. -Дахин боловсруулсан саарал усыг ДЦС-III, IV-д нийлүүлнэ.
- 3** Усны салбарын тогтвортой Улаанбаатар хотын усны менежментийн бодлогыг боловсронгуй болгох боломж бүрдэнэ. -Гэр хорооллын ус түгээх бүх цэгүүдэд ухаалаг систем суурилуулна. -Улаанбаатар хотын цэвэр усны нөөц жилд ойролцоогоор 68 сая шоо метрээр нэмэгдэнэ.

Улаанбаатар хот

Ус цэвэршүүлэх байгууламж

ДЦС III, IV

Ус дахин боловсруулах байгууламж

Санхүүжилт

АНУ-ын Мянганы сорилтын корпораци 350 сая ам.долларын буцалтгүй тусламж олгоно.

Монгол Улс нийт хөрөнгө оруулалтын 15 хувьас багагүй хэмжээний хөрөнгийг хариуцна.

Газрын гүний усны эх үүсвэр

Гэрээ хэрэгжих хугацаа: 5 жил

**“ИРГЭНИЙ БОЛОН АЖ АХУЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА
ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ
УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ” СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО**

2019.01.31

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**

7 бүлэг, 21 зүйлтэй

Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх төв байгууллага



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
**ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**



УЛСЫН ДЭЭД ШҮҮХ



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



УЛСЫН ДЭЭД ШҮҮХ



Гэрээгээр дараах нөхцөлийг тохирсон:



**Хоёр улсын иргэд адил нөхцөлөөр эрхээ
хамгаалуулахаар шүүхэд хандах**



Баримт бичиг гардуулах, дамжуулах



**Нотлох баримт олж авах, хэрэг хянан
шийдвэрлэх бусад ажиллагааг явуулах**



**Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх,
гүйцэтгэх**

“Иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-г соёрхон баталснаар хоёр улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хоорондын иргэний хэрэгтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх зарим ажиллагааг хоёр улсын хуулийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх боломжтой болж хууль ёсны эрх ашгаа хамгаалахад нь туслалцаа үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Хоёр тал соёрхон баталсан тухай Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

“ГЭМТ ЭТГЭЭД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ” СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2019.01.31

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн
журмаар



2018.06.04-нд
Талууд гарын үсэг зурсан



2019.01.31-нд
Гэрээ соёрхон батлах тухай
хуулийг баталсан

Гэрээ байгуулснаар:



Хууль сахиулах байгууллагууд харилцан гэмт этгээд шилжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, гэмт этгээдийг шилжүүлбэл зохих гэмт хэргийн төрөл, шилжүүлэхээс татгалзах үндэслэл, гэмт этгээдийг шаардлагатай тохиолдолд түр саатуулах болон шилжүүлэх ажиллагааг нарийвчлан тодорхойлсон.



**“ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН
ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ
УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ” СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**БАТАЛСАН
ОГНОО
2019.01.31**

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

**Ердийн
журмаар**



**2018.06.04-нд
Талууд гарын үсэг зурсан**



**2019.01.31-нд
Гэрээ соёрхон батлах тухай
хуулийг баталсан**

Гэрээ байгуулснаар:



Хууль сахиулах байгууллагууд хамтран ажиллах эрх зүйн орчин бүрдсэн тодорхой төрлийн ажиллагааг, тухайлбал нотлох баримт олж авах, мөрдөн шалгах ажиллагаанд холбогдох этгээдийг байлцуулах, гэмт хэргийн улмаас олдсон эд зүйл, хэрэгслийг хураан авах зэрэг ажиллагааг хоёр улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэхэд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэх боломжтой болсон



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР НЭЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

**БАТАЛСАН
ОГНОО**
2019.02.01

ХУУЛЬ САНААЧИЛСАН

Засгийн газраас
2018.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн
журмаар




Ерөнхий консулын газрын чиг үүрэг:

БНХАУ-ын зүүн болон зүүн өмнөд мужид ажиллаж, амьдарч буй иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, консулын үйлчилгээг ойртуулах.

Ач холбогдол

Монгол Улсыг сурталчлах, хөрөнгө оруулалт татах зорилгоор соёл, урлаг, хүмүүнлэгийн арга хэмжээ зохион байгуулах



Шанхайн банк, санхүү, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг судлах, дотоодын аж ахуйн нэгж олон улсын зах зээлд хувьцаа, IPO гаргахад дэмжлэг үзүүлэх



Далайд гарах, дамжин өнгөрөх тээврийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг болох зэрэг.

Шанхай хотод Монгол Улсын Ерөнхий консулын газрыг шинээр нээснээр тус хот болон Гуандун, Фужян, Жөжян, Анхуй, Жянсу мужид ажиллаж, амьдарч, суралцаж буй монгол иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдэнд консулын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, манай улсад жуулчлах, хөрөнгө оруулах зорилгоор зорчих Хятадын болон бусад улсын иргэдэд визийн үйлчилгээг ойртуулах зэрэг боломж нээгдэх юм. Тодруулбал, Шанхай хотод Ерөнхий консулын газар нээснээр тус хотоос гадна Хятадын зүүн болон зүүн өмнөд хэсгийн дээр дурдсан 5 мужийг тус Ерөнхий консулын газарт харьяалуулж, Бээжин дэх Элчин сайдын яамны консулын болон визийн үйлчилгээний ачааллыг бууруулах, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах боломж нэмэгдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ ХААЖ УИХ-ЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАРЫН ХЭЛСЭН ҮГ



Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулган ажлын **88** өдөр чуулж, өнөөдөр өндөрлөж байна. Намрын чуулганы хугацаанд Улсын Их Хурлын нэгдсэн чуулган **31**, Байнгын болон Дэд, түр хороод **92** удаа хуралдсан байна.

Намрын чуулганы хугацаанд бие даасан **5**, хуульд өөрчлөлт оруулах тухай **25**, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай **13**, хууль хүчингүй болсонд тооцох тухай **3** хууль, нийт **46** хууль, Улсын Их Хурлын **41** тогтоол хэлэлцэн баталлаа.

Улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан гишүүдийн ирц бүрдээгүйн улмаас есөн удаагийн чуулганы нэгдсэн хуралдаан тасалдсан. Гэхдээ Монгол Улсын 2019 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай зэрэг хуулийн хугацаатай, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал ач холбогдолтой асуудлуудаа шийдэж чадлаа.

Өнгөрсөн 2018 онд Ирээдүйн өв санд **620,7** тэрбум төгрөг, Төсвийн тогтворжуулалтын санд **206,9** тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Энэ онд нэгдсэн төсвийн нийт орлого болон тусламжийн дүнг **11,067.0** тэрбум төгрөгөөр баталж,

үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд **322.0** тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон нь өнгөрсөн оноос даруй **200.0** тэрбумаар илүү байна. Ирээдүйн өв санд **1,068.5** тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэн Хүний хөгжил сангийн үлдэгдэл өрийг төлж барагдуулснаар уг санд **550** гаруй тэрбум төгрөгийн хуримтлал үүсэх боллоо.

Ингэснээр Улсын Их Хурал, Засгийн газар өр биш өв үлдээдэг сайн жишиг тогтоож байна.

Нийгэмд хүлээлт үүсгэсэн, зайлшгүй шийдвэл зохих хөрөнгө оруулалтын болон бусад зардлыг төсөв, санхүүгийн боломжтой уялдуулан шийдвэрлэх чиглэлийг Улсын Их Хурлаас тууштай баримталж ажиллалаа.

Тухайлбал, 2019 оны төсөвт **123** сургууль, сургууль-цэцэрлэгийн цогцолбор **7**, цэцэрлэгийн **176** барилга барих хөрөнгийг суулгаж, **58** сургууль, **5** сургууль-цэцэрлэгийн цогцолбор болон **134** цэцэрлэгийн барилгыг 2019 онд ашиглалтад оруулахаар төлөвлөлөө.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийг баталж гаргалаа.

Ирэх онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь бүхэлдээ санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэж, эдийн засагт бий болж байгаа эерэг хандлага, үр нөлөөг бэхжүүлэх, цаашид эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэрэг бодлогын арга хэмжээг хамарч байгаагаараа онцлог болсон гэж үзэж байна.

Харин энэ намрын чуулганы завсарлагаанаар валютын ханш, үнийн өсөлтийн талаар ажлын хэсэг байгуулж, цаашид авах арга хэмжээний талаар үнэлэлт, дүгнэлт боловсруулах ажлыг эрчимтэй зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Оны эхнээс дагаж мөрдөж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн биелэлтийг хангахад шаардлагатай холбогдол бүхий дүрэм, журмыг намрын чуулганд багтаан баталлаа. Төрийн албаны зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг хуулийн дагуу бүрдүүллээ.

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй мөрдүүлж, төрийн бодлого, үйл ажиллагааны залгамж чанарыг хадгалах, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах, төрийн албанд чадахуйн зарчмыг

хэвшүүлж, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж хууль дээдэлж, хуулийг ягштал биелүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн, төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүгээр үүрэг, чиглэл болгож байна.

Ард иргэд төрийн бүх шатанд ажиллаж байгаа албан хаагчдаас сахилга хариуцлага, ёс зүйг эрхэмлэн, хариуцсан ажилдаа сэтгэл, зүтгэлтэй, санаачилгатай байхыг хүсэж, хүлээж байна. Сахилга, хариуцлага дээрээс эхэлж, доош үлгэрлэдэг, хууль журам нь эрх мэдэлтнүүдэд хатуу, эгэл жирийн ард иргэдэд нигүүлсэнгүй байх нь төрт ёсны эрхэм чанар болохыг дахин анхааруулж байна.

Агаарын бохирдлыг бууруулах ажлыг хариуцсан байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон зарцуулсан хөрөнгө, үр дүнг тодруулах зорилгоор Ерөнхий хяналтын сонсголыг анх удаа зохион байгуулсан нь энэ чуулганы бас нэг онцлох үйл явдал боллоо.

Цаашид иргэдийн оролцоотой нийтийн сонгол хийх замаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийг удирдах хэрэгт иргэдийг оролцуулах, иргэдийн бүтээлч санал, санаачилгыг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэхэд Улсын Их Хурал анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы танхим популизмын индэр, хэрүүлийн тайлбар байх учиргүй. Ард олны хүсэмжлэл, олон нийтийн санал, бодолд нийцсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, баримт нотолгоонд суурилсан парламентын мэтгэлцээн нь парламентат ёс, парламентын соёлыг төлөвшүүлэхэд гарцаагүй чухлыг бид анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүний тулд Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж, олон улсын парламентын зарим дэвшилт зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэтгэлцээний зарчмыг Улсын Их Хуралд нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Улсын Их Хурлын ээлжит чуулган завсарлах нь амралт биш юм. Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган завсарлах дөхсөнтэй холбогдуулан гишүүд амрах гэж байгаа гэх мэт буруу, ташаа мэдээлэл их явж байна.

Монгол Улсын Их Хурал бол байнгын ажиллагаатай парламент. Парламентын бүрэн эрхээ чуулган болон зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлдэг. Тодорхой хугацаанд тогтмол чуулж, завсарлаж байх Үндсэн хуулийн зохицуулалттай институц.

Ард түмнээс мандат авч, тэднийг төлөөлөн төрийн эрх барьж байгаагийн хувьд чуулганы завсарлагааны хугацаанд иргэд, сонгогчидтойгоо ойр ажиллаж, ард иргэдээ сонсож, Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж, бодлогыг тайлбарлан таниулах ажил хийх нь Та бидний үүрэг байх ёстой.

Мөн чуулганы завсарлагааны хугацаанд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, сонгуулийн хууль тогтоомжийн шинэчлэл, улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг эцэслэн боловсруулах чиглэлд ажлын хэсгүүд идэвхтэй ажиллаж, ирэх хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг сайтар хангаж ажиллахыг үүрэг чиглэл болгож байна.

Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрхээс гадна хянан шалгах бүрэн эрхийн хэрэгжилтийг хангах чиглэлээр илүү санаачилга гаргаж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Завсарлагааны үеэр Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хангах чиглэлээр Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын хорооны тогтоолоор холбогдох ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулах болно.

Нийгэмд эргэлзээ төрүүлсэн, шийдэгдэхгүй байгаа томоохон хэргүүдийг эцэслэж, нийгмийн шударга бус байдлыг халах, хуулийн хэрэгжилтийг хангах талаар Улсын Их Хурлаас хянан шалгах түр хороодыг байгуулах асуудлыг шийдвэрлэх болно.

Татварын багц хуулиуд болон төрийн худалдан авах ажиллагааг зохицуулах хууль тогтоомжийг шинэчлэх зэрэг шийдлээ хүлээж байгаа нийгэм, эдийн засгийн амин чухал асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор ээлжит бус чуулган зарлан хуралдуулах болно гэдгийг энд онцлон тэмдэглэж байна.

Удахгүй болох монгол түмний уламжлалт баяр Цагаан сарын мэндчилгээг ард түмэндээ хүргэж, төрлөөрөө түвшин амгалан, элгээрээ энх амгалан, төр улсаараа элбэг дэлбэг, төрөл садан, хотлоороо сайхан шинэлэхийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган өндөрлөснийг мэдэгдье.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
АНДОПЧ	Ази-Номхон далайн орнуудын парламентын чуулган
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АПА	Азийн парламентын ассамблей
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХХААБХ	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ЁЗДХ	Ёс зүйн дэд хороо
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
НББСШУБХ	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУПХ	Олон Улсын Парламентын Холбоо
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨБХ	Өргөдлийн байнгын хороо
СБД	Сүхбаатар дүүрэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТЗХДХ	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТХДХ	Тусгай хяналтын дэд хороо
ТХЗДХ	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо
УИХГХБДХ	Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХК	Хувьцаат компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХЭДХ	Хүний эрхийн дэд хороо
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2018 ОНЫ НАМРЫН
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Редактор:	С.Батбаатар
Эмхэтгэсэн:	Ц.Оюун
Эх бэлтгэсэн:	Т.Цэнд-Аюуш
Гэрэл зургийг:	Г.Эрдэнэтуяа А.Батжаргал

Улсын Их Хурлын Тамгын газраас
2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх, олшруулах цехэд 1350 ширхэг хэвлэв.
